



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,  
НИЙТЛЭЛ)

*Монгол Улсын Их Хурлын Тамгын газар*

№ 1993 оны 1—3 сар

№ 2 (13)

## ГАРЧИГ

### 1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Гэрээ соёрхон батлах тухай Монгол Улсын хууль	153
2. Монгол Улсын онцгой албан татварын хууль	154
3. Монгол Улсын шүүхийн тухай хууль	156
4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль	177
5. Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн хууль	178
6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль	184
7. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль	204
8. Хуулийг дагаж мөрдөх хугацааг хойшлуулах тухай Монгол Улсын хууль	210

### 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫН ТОГТООЛ

9. Онцгой албан татварын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 12	211
10. Аймчлалын дүнгийн тухай № 13	212
11. Хуулийн төсөл буцлах тухай № 14	213
12. Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 15	214
13. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 17	217
14. Бүгд Найрамдах Босни-Герцеговина Улстай дипломат харилцаа тогтоох тухай № 18	218
15. Бүгд Найрамдах Словени улстай дипломат харилцаа тогтоох тухай № 19	219

16. Бүгд Найрамдах Хорват улстай дипломат харилцаа тогтоох тухай № 20	220
17. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай № 22	220
18. Зарим барааг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай № 23	221
19. Р. Жамъянчойжиланг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилгох тухай № 24	222
20. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль товлон барлах тухай № 25	223
21. Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай № 26	224
22. Монгол Улсын Үндсэн хуулийн гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай № 27	225
23. Шалгалт хийх тухай № 28	226

### 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИГЛӨГЧИЙН ЗАРИМГ

24. Ч. Цэрэндагвад хошууч генерал цол олгох тухай № 12	227
25. Зарим хүнийг Сүхбаатарын одонгоор шагнах тухай № 13	227
26. Э. Галсанданзанг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай № 14	228
27. Казуо Такемотог найрамдал медалаар шагнах тухай № 15	229
28. Э. Бямбажавыг хэвсрэн суух Элчин сайдаар томилгох тухай № 16	229
29. Б. Шарыг шударга журам медалаар нэхэн шагнах тухай № 19	230
30. Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн даргын тухай № 25	231
31. Н. Очирбалыг Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 42	231
32. А. Мундагбаатарыг Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 43	232
33. Ж. Ганибалыг элчин сайдаар томилгох тухай № 44	232
34. Ж. Ганибалыг Элчин сайдаар томилгох тухай № 45	233
35. Б. Цэрэндоржийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилгох тухай № 51	233
36. Дэлхийн монголчуудын «Их чуулган» зохион байгуулах тухай № 52	234
37. Зарим хүнийг медалаар шагнах тухай № 53	235
38. Лүдэндоржийн Хашбатыг Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 54	235
39. Хэсбазарын Бэхбатыг Элчин сайдаар томилгох тухай № 55	236
40. Г. Даштүвшнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилгох тухай № 56	236
41. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол № 1	237
42. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол № 2	241
43. Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	252
44. Азийн зарим орны парламент	261
45. Хаягаа тодорхой бичээрийг	266

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

1993 оны 1 дүгээр  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

ГЭРЭЭ СОЕРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Засгийн газраас 1992 оны дөрөвдүгээр сарын 17-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан «Орлогын татварыг давхар ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийхийг сэргийлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хоорондын Хэлэлцээр»-ийг соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын  
эд дарга

**Ж. ГОМЕОЖАВ**

Монгол Улсын Их Хурлын  
Тамгын газрын ерөнхий  
лэрийн бичгийн дарга

**Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬ

### *1 дүгээр зүйл. Хуулийн зорилт*

Энэ хуулийн зорилт нь импортын болон эх орны үйлдвэрийн зарим бараанд онцгой албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон хариацааг зохицуулахад оршино.

### *2 дугаар зүйл. Онцгой албан татварын хууль тогтоомж*

Онцгой албан татварын хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### *3 дугаар зүйл. Онцгой албан татвар төлөгч*

Энэ хуулийн дагуу онцгой албан татвар ногдох бараа импортолж, үйлдвэрлэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага албан татвар төлөгч байна.

### *4 дүгээр зүйл. Онцгой албан татвар ногдох бараа*

Дараахь бараанд онцгой албан татвар ногдоно:

- 1) бүх төрлийн согтууруулах ундаа;
- 2) бүх төрлийн тэмх;
- 3) алт, мөнгөн эдлэл.

### *5 дугаар зүйл. Онцгой албан татвар тооцох үнэлгээ*

1. Импортын барааны онцгой албан татвар тооцох үнэлгээг уг барааны гэрээний үнэ, тээврийн зардал, даатгалын хураамжийг тухайн үед мөрдөж байгаа Монголбанкнаас тогтоосон валютын ханшаар тогтогт шилжүүлсэн үнэ дээр гаалийн албан татварыг нэмж тодорхойлно.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн барааны онцгой албан татвар тооцох үнэлгээг уг барааг үйлдвэрлэгчээс борлуулсан үнийг үндэслэн тодорхойлно.

3. Импортолсон болон борлуулсан барааны үнэ нь тодорхойгүй бол онцгой албан татвар тооцох үнэлгээг Сангийн сайдын тогтоосон журмын дагуу импортын барааны тухайд гаалийн байгууллага, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн барааны тухайд Улсын татварын алба тодорхойлно.

4. Онцгой албан татвар ногдох барааг үйл ажиллагааны хамаараал бүхий аж ахуйн нэгж, байгууллагад үндэслэлгүй доогуур үнээр борлуулсан бол онцгой албан татвар тооцох үнэл-

гээг хэмжээлгүй аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан үнээр төлөрхөйлно.

*6 дугаар зүйл.* Онцгой албан татварын хувь, хэмжээ

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан барааны үнэлгээнд дараахь хувиар онцгой албан татвар ногдуулна:

Онцгой албан татвар ногдуулах барааны нэр төрөл	Онцгой албан татварын хувь	
	эх орны үйлд- вэрийн бараанд	импортын бараанд
1. Хүнсний спирт	85	150
2. Бүх төрлийн архи	80	100
3. Бүх төрлийн дэрс	30	50
4. Бүх төрлийн тамхи	—	100
5. Алтан эдлэл	40	—
6. Мөнгөн эдлэл	10	—

2. Алт, мөнгөн эдлэлийн онцгой албан татварыг уг эдлэлийг хийхэд зарцуулах алт, мөнгөний үнээс энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувиар тусгаж байх журмыг Засгийн газар тогтоож болно.

*7 дугаар зүйл.* Онцгой албан татвараас чөлөөлөх

Дараахь барааг онцгой албан татвараас чөлөөлнө:

1) Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж экспортод гаргасан бараа;

2) үйлдвэрлэлийн зорнуулаатаар хүнсний үйлдвэр, комбинатад нийлүүлсэн, түүнчлэн хүл, мал эмнэлгийн хэрэгцээнд өлгөсөн спирт;

3) ивио, гэрийн нөхцөлд энгийн аргаар ирсэн шимийн архи;

4) хайрын тамхи, дүрсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи.

*8 дугаар зүйл.* Онцгой албан татварыг ногдуулах, төсөвт төлөх

1. Импортын бараанд ногдох онцгой албан татварыг уг бараа Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирсэн тухай бүрт гаалийн байгууллага ногдуулан гаалийн албан татварын хамт өөрийн дансанд оруулна. Гаалийн байгууллага онцгой албан татварыг дансанд орсноос хойш 3 хоногийн дотор улсын төвлөрсөн төсөвт шилжүүлнэ.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн благаанд ногдох онцгой албан татварыг сар бүрийн 11, 21 болон сарын сүүлчийн өдөр төсөвт төлж, тайланг дэрла сарын 5-ны дотор Улсын татварын албанд тушаана.

Монгол Улсын Их Хурал  
дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

Монгол Улсын Их Хурал  
Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

1993 оны 4 дүгээр  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### *Нийтлэл үндэслэл*

#### *1 дүгээр зүйл. Хуулийн зорилт*

Энэ хуулийн зорилт нь шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, түүнчлэн шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### *2 дугаар зүйл. Шүүхийн тухай хууль тогтоомж*

Шүүхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### *3 дугаар зүйл. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх*

1. Үндсэн хуульд зааснаар Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

2. Шүүх хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн.

3. Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, маргааныг шүүхээс өөр байгууллага, албан тушаалтан шийдвэрлэх эрхгүй.

4 дугаар зүйл. Шүүхийн тогтолцоо

1. Шүүхийн үндсэн тогтолцоо нь Монгол Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

2. Эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх (дээшнд «дагнасан шүүх» гэх) байгуулж болно.

5 дугаар зүйл. Шүүх байгуулах

1. Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийг аймаг, нийслэлийн Засаг даргатай, дагнасан шүүхийг Улсын дээд шүүхтэй тус тус зөвшилцөн гаргасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн (дээшнд «Ерөнхий зөвлөл» гэх) саналыг үндэслэн Улсын Их Хурал байгуулж, өөрчилж, татан буулгана.

2. Шүүх байгуулахдаа түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн эмийн нягтрал, аж ахуйн нэгж, байгууллаагчын тоо, хэрэг, маргааны гаралтын түвшинг хөргалзан үзнэ.

3. Монгол Улсад зүйл, аж ахуйн нэгж, байгууллага хууль, шүүхийн эмнэ эрх тэгш байх зарчимд харшлах болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх талаар хуулиар тогтоосон нийтлэг журмыг үл баримтлах шүүх байгуулахыг хориглоно.

6 дугаар зүйл. Шүүгч, түүнийг томилгох

1. Шүүгчээр Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлд заасан болвалыг хангасан, ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг томилно.

2. Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

3. Улсын дээд шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлөөс Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно.

4. Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүх, дагнасан шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор шүүгчдийн дотроос Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно.

5. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно.

6. Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг уанруулам томилж болно.

7. Ерөнхий шүүгч түр эвгүйд түүнийг тухайн шатны шүүхийн шүүгчээр замгийн олон жинд ажиллаасан, хэрвэ ажиллаасан хугацаа адил бол ахмад шүүгч орлоно.

8. Ерөнхий шүүгч болон шүүгчээр томилуулахаар санал болгосон хүнийг Ерөнхийлөгч татгалзвал Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар сөр хүнийг санал болгоно.

*7 дугаар зүйл. Шүүгчийн бүрэн эрх*

1. Бүх шатны шүүхийн шүүгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Ерөнхий шүүгчийн томилосноор шүүх хуралдааныг даргах буюу түүнд оролцох;

2) шүүх хуралдааныг товлон зарлаж, түүний оролцогчдыг тогтоох;

3) шүүх хуралдааны бэлтгэл хангах ажлыг зохицуулан удирдах;

4) хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдуулаж иргэн, албан тушаалтныг дуудан ирүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай нотлох баримт гаргуулан авах, тэдний шийдвэр төр, аж ахуйн нэгж, байгууллагын хууль ёсны ашиг сонирхол, хүний эрх, эрх чөлөөнд ноцтой хохирол учруулахаар байвал түүнийг биелүүлэх ажиллагааг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд түдгэлзүүлэх, шинжлэх томилон дүгнэлт гаргуулах болон хуульд заасан байцаан шийтгэх бусад ажиллагааг явуулах;

5) давж заалдах болон хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх үед доод шатны шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг хуульд заасан үндэсрэл, журмын дагуу түдгэлзүүлэх;

6) албан үүрэгтэй нь холбогдож нлэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;

7) хууль тогтоомжинд заасан бусад бүрэн эрх.

2. Шүүгч хуулиар тогтоосон үүрэгт нь хамаарахгүй ажил, албан тушаал хавсарч болохгүй. Харин багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж болно.

*8 дугаар зүйл. Шүүх бүрэлдэхүүн*

1. Анхан шатны журмаар хэрэг, маргааныг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр, хуульд тусгайлан заасан тохиолдолд шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.



2. Давж заалдах шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд 3 шүүгч оролцож.

3. Улсын дээд шүүх нийт шүүгчийн олонхийн бүрэлдэхүүнтэйгээр хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэнэ.

4. Анхан шатны болон давж заалдах, хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд урьд нь оролцсон шүүгч уг хэрэг, маргааныг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

*9 дүгээр зүйл. Шүүгчийн тангараг, шүүхийн бэлгэ тэмдэг*

1. Шүүгч томилгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор «Шүүгч би алмаад хэрэг, маргааныг зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, шударга ёсыг чанд сахин явахдаа батлан тангараглая. Хэсэг миний бие өргөсөн тангаргаасаа няцвал хуульд заасан хариуцлага хүлээнэ» хэмээн тангараг өргөнө.

2. Шүүх бэлгэ тэмдэгтэй байна.

3. Шүүгчийн тангараг өргөх журам, шүүхийн бэлгэ тэмдэг, түүний дүрмийг Ерөнхийлөгч батлана.

*10 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр*

1. Анхан шатны шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлээд тэснэн шийдвэрлэх тогтоол, эрх зүйн маргааныг хянан шийдвэрлээд шийдвэр, шийтгэвэр, давж заалдах шатны шүүх магадлаа, хяналтын шатны шүүх тогтоол, байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэр биелүүлэхтэй холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж (цаашид «шүүхийн шийдвэр» гэх) гаргана.

2. Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ шийдвэрээ олонхийн саналаар гаргана.

3. Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргаж, төрийн сүлд бүхий хэвдэмэл хуудсан дээр үйлдэн шүүх бүрэлдэхүүн гарин үсэг зурж, тамга дарна.

*11 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх*

1. Шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хүн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага заавал биелүүнэ.

2. Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан биелүүнэ.

3. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх журмыг хуулиар тогтооно.

*12 дугаар зүйл. Шүүхийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас*

1. Шүүх соёмбо бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэгтэй байна.

2. Шүүх албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

*13 дугаар зүйл. Шүүх хуралдааны танхим*

1. Шүүх хуралдааныг шаардлага хангасан танхимд явуулна.

2. Шүүх хуралдааны танхимд төрийн далбаа, шүүхийн баалга тэмдгийг байрлуулна.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

*Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим*

*14 дугаар зүйл. Шүүгч гагцхүү хуульд захирагдах*

1. Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдана.

2. Шүүгчийн хараат бус байдал Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажина.

*15 дугаар зүйл. Мэтгэлзэх зарчим*

1. Шүүн таслах ажиллагааг мэтгэлзэх үндсэн дээр хэрэгжүүлнэ.

2. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд прокурор, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд зохигчид, тэдний төлөөлөгч, өмгөөлөгч, түүнчлэн хуулиар эрх олгосон бусад оролцогч хэрэг, маргааныг үйл баримт шүүгдэгчийн болон зохигчдын гэм буруу байгаа эсэхийг шүүхэд нотлох замаар мэтгэлзэнэ.

*16 дугаар зүйл. Хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч оролцох*

1. Шүүх анхан шатны журмаар хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ 3 хүртэл иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

2. Иргэдийн төлөөлөгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) хэрэг, маргааны үйл баримт, шүүгдэгч болон зохигчдын гэм буруугийн талаар дүгнэлт өгөх;

2) хэрэг, маргааны үйл баримт, шүүгдэгчдийн болон зохигчдын гэм буруугийн асуудлаар шүүхийн шийдвэрт гомдол гаргах;

3) хуульд заасан бусад бүрэн эрх.

3. Иргэдийн төлөөлөгч дүгээлтээ бичгээр гэргаж шүүх хуралдаанд уншиж сонгоно.

4. Хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхэд оролцох иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

*17 дүгээр зүйл.* Иргэдийн төлөөлөгчийг сонгох

1. Иргэдийн төлөөлөгчийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Тэргүүдэгчдийнхээ саналыг үндэслэн 4 жилийн хугацаагаар сонгоно.

2. Иргэдийн төлөөлөгчдийн тоог Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

3. Иргэдийн төлөөлөгч тухайн шүүхийн харьяалан ажлаах нутаг дэвсгэрт хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцоно.

*18 дүгээр зүйл.* Гэм буруутайд тооцож үл болно.

Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.

*19 дүгээр зүйл.* Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гэрэл, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага өмчийн хэлбэр, эрх хэмжээний ялгааргүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

*20 дүгээр зүйл.* Өмгөөлөх, өмгөөлүүлэх эрх

1. Шүүгдэгч болон шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгон авах, хэргийн баримт салттай танилцах, шүүх хуралдаанд биеэр оролцох эрхтэй. Харин хуульд өөрөөр заагаагүй бол шүүгдэгчийг шүүх хуралдаанд заавал биеэр оролцуулна.

2. Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийг тайлбарлаж энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүрэг хүлээнэ.

3. Өмгөөлөлийн хэлс төлөх чадваргүй шүүгдэгчид төрөөс туслахаа үзүүлнэ.

*21 дүгээр зүйл.* Шүүн таслах ажиллагааг явуулах хэл

1. Шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулна.

2. Монгол хэл мэдэхгүй хүн хэргийн баримт салтныг хэлмэрчлүүлэн бүрэн танилцах, шүүх хуралдаан дээр эх хэлээрээ үг хэлэх, хэлмэрч авах эрхтэй.

22 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

1. Шүүх хуралдааныг нээлттэй явууна.

2. Хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэг, маргааныг шүүх хуралдаанаар хаалттай хянан шийдвэрлэнэ.

23 дугаар зүйл. Шүүхээс хууль хэрэглэх

1. Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулийг хэрэглэнэ.

2. Шүүх Үндсэн хуульд нийцээгүй, хэрэг, маргаан гарах үед хүчин төгөлдөр болоогүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.

3. Шүүх тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар санал оруулна. Улсын дээд шүүх уг саналыг хэлэлцэж үндэслэлгүй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсвэтгэв мэдүүлнэ.

4. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж мөрднө.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Монгол Улсын шүүх

24 дугаар зүйл. Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх

1. Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллаага мөн.

2. Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, 16 шүүгчээс бүрдэнэ.

3. Улсын дээд шүүх дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүхийн давж заалдах шатны шүүхийн шийдвэртэй хэрэг, маргааныг Улсын дээд шүүхийн гурваас доошгүй шүүгчийн саналыг үндэслэн хяналтын журмаар хянан шийдвэрлэх;

2) Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүхийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэрэг, маргааныг шүүх хуралдаанд оролцогчдын гомдлыг үндэслэн давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх;

3) хуулиар харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

4) шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулж, нийт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах. Энэ нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хамаарахгүй;

5) хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

6) Үндсэн хуулаас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсын тайлбар гаргах. Улсын дээд шүүхийн тайлбарыг тухайн хуулийг хэрэглэж байгаа хүн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрднө.

7) Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр томилуулах шүүгчийн тухай санал гаргах;

8) Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах хүний тухай санал гаргах;

9) нэр дэвшсэн шүүгчдээс Ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгох;

10) цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэртэй хэргийг хяналтын шатны журмаар заавал хянан шийдвэрлэх;

11) хуульд заасан бусад бүрэн эрх.

25 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

1. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Улсын дээд шүүхийг тэргүүлж, түүнийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

2) Улсын дээд шүүх анхан шатны болон давж заалдах шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг томилох;

3) Улсын дээд шүүхийн хуралдааныг товлон зарлаж даргалал;

4) Улсын дээд шүүхийн байгууллага, шүүгч, ажлын үйл ажиллагааг зохицуулах;

5) Ерөнхий зөвлөлийн гишүүнд шүүгчийн нэр дэвшүүлэх;

6) хууль тогтоомжид заасан бусад эрх.

2. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч өөрийн ажлын албатай байна.

3. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч эрх хэмжээнийхээ асуудлаар захирэмж гаргана.

26 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн шүүх, түүний бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн шүүх давж заалдах шатны шүүх мөн.

2. Аймаг, нийслэлийн шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

3. Аймаг, нийслэлийн шүүх дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэртэй хэрэг, маргааныг шүүх хуралдаанд оролцогчдын гомдлыг үндэслэн давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх;

2) хуулиар харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

3) сум буюу сум дундын, дүүргийн шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах. Энэ нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хамаарахгүй;

4) хуульд заасан бусад бүрэн эрх.

27 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) аймаг, нийслэлийн шүүх анхан шатны болон давж заалдах шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг томлох;

2) аймаг, нийслэлийн шүүхийг төргүүлж, түүнийг төлөөлөх, шүүгч, ажилтны үйл ажиллагааг зохицуулах;

3) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

28 дүгээр зүйл. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүний бүрэн эрх

1. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх анхан шатны шүүх мөн.

2. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

3. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) хуулиар Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, дагнисан шүүхэд харьяалуулснаас бусад хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

2) хуульд заасан бусад бүрэн эрх.

29 дүгээр зүйл. Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг томлоох;

2) шүүхийг төргүүлж, түүнийг төлөөлөх, шүүгч, ажилтны үйл ажиллагааг зохицуулах;

3) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

*30 дугаар зүйл. Дагнасан шүүх*

1. Дагнасан шүүх нь шүүн таслах ажлын төрлөөр байгуулагдсан шүүх мөн бөгөөд түүнийг анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн гэлбэрээр байгуулж болно.

2. Дагнасан шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

3. Дагнасан шүүх дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) хуулиар харьяалуулсан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх;

2) хуульд заасан бусад бүрэн эрх.

4. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

*31 дүгээр зүйл. Дагнасан шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн бүрэн эрх*

Дагнасан шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч энэ хуульд заасан адилтгах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн бүрэн эрх, түүнчлэн хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Ерөнхий зөвлөл*

*32 дугаар зүйл. Ерөнхий зөвлөл, түүний үүрэг*

1. Үндсэн хуульд зааснаар Ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий хамтын удирдлагын, орон тооны бус байгууллага мөн.

2. Ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гэгцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ангийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах үүргийг хэрэгжүүлнэ.

3. Ерөнхий зөвлөл соёмбо бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

*33 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн*

1. Ерөнхий зөвлөл 12 гишүүнээс бүрдэнэ.

2. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал

эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга албан тушаалаараа, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчөөс томилсон тус бүр нэг хүн, зохих журмын дагуу нэр дэвшүүлж Улсын дээд шүүх сонгосон, бүх шатны шүүхээс тус бүр 2 шүүгч орно.

3. Ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо олонхийн санааар, 3 жилийн хугацаагаар сонгоно. Түүнийг улируулан сонгож болно.

*34 дүгээр зүйл.* Ерөнхий зөвлөлийг байгуулах, түүний гишүүний бүрэн эрхийн хугацаа

1. Улсын Их Хурлаас томилогдох Ерөнхий зөвлөлийн гишүүнийг Улсын Их Хурлын дарга нэр дэвшүүлж, чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санааар томилно.

2. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох Улсын дээд шүүхийн шүүгчийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, аймаг, нийслэлийн болон сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн хуралдаанаас тус тус нэр дэвшүүлж, Улсын дээд шүүхийн хуралдаанд оролцогчдын олонхийн санааар сонгоно.

3. Ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн даргаар шүүхийн ажлын дадалага туршлагатай хүнийг Ерөнхий зөвлөлийн дарга санаа болгосноор Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.

4. Ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга орон тоонд байж, Шүүхийн тамгын газрыг толгойлно.

5. Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр бүрдсэнээр түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

6. Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Энэ хугацаа албан тушаалаараа Ерөнхий зөвлөлд орсон гишүүдэд хамаарахгүй.

7. Ерөнхий зөвлөлийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоод хүчин төгөлдөр болсон, гишүүний үүргээ зохих ёсоор биелүүвэггүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар биелүүлэх боломжгүй болсон бол Ерөнхий зөвлөлийн санаа буюу өөрийнх нь хүсэлтийг үндэслэн түүнийг томилсон буюу сонгосон байгуулаага хугацаанаас нь өмнө чөлөөлөх, огцруулах асуудлыг шийдвэрлэнэ.

8. Ерөнхий зөвлөлийн гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн буюу огцорсон бол энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан журмын дагуу нөхөн томлох буюу сонгодо.

*35 дүгээр зүйл.* Ерөнхий зөвлөлийн бүрэн эрх

Ерөнхий зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



1) зохих байгууллага, албан тушаалагчтай зөвшилцөн Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршлыг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд оруулах;

2) бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд оруулах;

3) шүүхийн төсвийн төслийг зохих журмын дагуу Улсын Их Хуралд оруулах, батлагдсан төслийг хуваарилах;

4) шүүгчийг томилуулах, чөлөөлүүлэх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

5) шүүгчийг шилж олох, шалгаруулах;

6) шүүгчийн сахлагын хөрөөг байгуулах;

7) шүүгчийг шилжүүлэн томлох;

8) шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах болон шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргах журам, шалгуурыг тогтоох;

9) шүүгч, шүүхийн болон шүүхийн байгууллагын ажилтныг шагнаж урамшуулах, эрх ашгийг нь хамгаалах;

10) шүүхийн хуяг, тогтоод гүйцэтгэгчээс албаны дүрэмт хувцас, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг зохих байгууллаагатай зөвшилцөн тогтоох;

11) хууль, тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

*36 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн даргын бүрэн эрх*

1. Ерөнхий зөвлөлийн дарга Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Ерөнхий зөвлөлийг тэргүүлж, түүнийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

2) Ерөнхий зөвлөлийн хуралдааныг товлон, даргаалах;

3) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

2. Ерөнхий зөвлөлийн даргыг түр эзгүйд түүнийг томилсон Ерөнхий зөвлөлийн гишүүн орлоно. Харин Ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга орлож болохгүй.

*37 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх*

Ерөнхий зөвлөлийн гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэх санал оруулах;

2) Ерөнхий зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох;

3) Ерөнхий зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангуулах;

4) шүүхийн тамгын газар, хэлтэс, тэдгээрийн ажилтны ажлыг шалгах;

5) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

*38 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн хуралдаан*

1. Ерөнхий зөвлөд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн иргэйтэйгээр хэлэлдэн хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

2. Ерөнхий зөвлөлийн тогтоолд дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тамга дарна.

3. Ерөнхий зөвлөл хуралдааныхаа дэгийг тогтооно.

*39 дүгээр зүйл. Шүүгчийн сахлагын хороо*

1. Шүүгчийн сахлагын хороог 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, 6 жилийн хугацаагаар Ерөнхий зөвлөл байгуулна.

2. Шүүгчийн сахлагын хорооны бүрэлдэхүүнд өндөр мэргэшилтэй, ажил, амьдралын туршлагатай шүүгчдийг оруулна. Сахлагын хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн гишүүн орохгүй.

3. Шүүгчийн сахлагын хороо зөрчил гаргасан шүүгчид энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу сахлагын шийтгэл хүлээлгэх асуудлыг эрхлэнэ.

4. Шүүгчийн сахлагын хорооны даргыг гишүүд нь дотроосоо олонхийн саналаар сонгоно.

5. Шүүгчийн сахлагын хорооны дүрмийг Ерөнхий зөвлөл батална.

*40 дүгээр зүйл. Шүүгчид нэр дэвшүүлэх*

1. Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, хуульчдын мэргэжлийн олон нийтийн байгууллагын удирдах байгууллага, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шүүгчид нэр дэвшүүлэх эрхтэй.

2. Үндсэн хууль болон энэ хуульд заасан болзол хангасан Монгол Улсын иргэн шүүгчид өөрийн нэрийг дэвшүүлж болно.

*41 дүгээр зүйл. Шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэх*

Шүүгчид нэр дэвшигчийг хуульд заасан шаардлагыг хангаж буй эсэхийг судалсны үндсэн дээр түүний оршин суугаа газрын шүүхийн тамгын газар, хэлтэс бүртгэнэ.

*42 дүгээр зүйл. Шүүгчид нэр дэвшигчийг шалгаруулах*

1. Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийн мэргэжлийн түвшин, ажил хэргийн чадвар, хувийн зан суртахуун, биеийн эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан нэр дэвшигч нэг бүрээр хэлэлцэж нууцаар санал хурааж олонхийн санал авсан нэр дэвшиг-

чийг шүүгчээр томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

2. Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан Ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийн байна.

43 дугаар зүйл. Шүүгчид хүлээлгэх хариуцлага

Шүүгч өөрийн хууль бус ажиллагааны болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөний төлөө энэ хууль, бусад хуульд заасан хариуцлага хүлээнэ.

44 дүгээр зүйл. Сахиагын шийтгэл ногдуулах үндэслэл

1. Шүүгчийн тангарагт харш дараахь зөрчил гаргасан шүүгчид сахиагын шийтгэл ногдуулна:

1) хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хууль зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал;

2) шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн;

3) байгууллагын дотоод журам ноцтой зөрчсөн.

2. Шүүгчид сахиагын шийтгэл ногдуулах үндэслэл нь зохих журмын дагуу хийсэн шалгалтаар тогтоогдсон байвал зохино.

45 дугаар зүйл. Сахиагын шийтгэл

1. Гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан шүүгчид дараахь сахиагын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:

1) сануулах;

2) шүүгчдийн өмнө буруушаан зэмлэх;

3) шүүгчээс огцруулах.

2. Сахиагын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахиагын шийтгэл ногдуулж болохгүй.

3. Шүүгчид үүсгэсэн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон боловч уг зөрчилд сахиагын хэрэг үүсгэх үндэслэлтэй байвал эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоол гарсан өдрөөс хойш нэг сарын дотор эрх бүхий этгээд түүнд сахиагын хэрэг үүсгэж болно.

46 дугаар зүйл. Сахиагын хэрэг үүсгэх үндэслэл

Шүүгчид сахиагын хэргийг дараахь үндэслэлээр үүсгэнэ:

1) шүүгч хууль, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн нь давж заалдах болон хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад илэрсэн;

2) шүүгч хууль, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэдийн гомдол, мэдээллийг үндэслэлтэй гэж үзсэн.

*47 дугаар зүйл. Сахилагын хэрэг үүсгэх эрх*

1. Сахилагын хэрэг үүсгэх эрхийг дараахь шүүх бүрэлдэхүүн, байгууллага, албан тушаалтан эдэлнэ:

1) Улсын дээд шүүхийн хуралдаан, давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн, Ерөнхий шүүгч, Ерөнхий зөвлөл Монгол Улсын бүх шүүгчдэд;

2) аймаг, нийслэлийн шүүхийн давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч тухайн аймаг, нийслэлийн болон сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчдэд;

3) сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч тухайн шүүхийн шүүгчдэд.

2. Сахилагын хэрэг үүсгэсэн тухай шүүх бүрэлдэхүүн, Ерөнхий зөвлөл тогтоол, Ерөнхий шүүгч захирамж гаргана.

3. Сахилагын хэрэг үүсгэсэн шүүх бүрэлдэхүүн, албан тушаалтан тогтоол, захирамжаа холбогдох баримт сэлтийн хамт 5 хоногийн дотор шүүгчийн сахилагын хороонд шилжүүлнэ.

*48 дугаар зүйл. Сахилагын хэргийг шалгаж шийдвэрлэх хугацаа*

1. Шүүгчийн сахилагын хороо сахилагын хэрэг үүсгэсэн тогтоол, захирамжийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор шалган сахилагын хорооны 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ. Тухайн сахилагын хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнийг шүүгчийн сахилагын хорооны дарга томилно.

2. Тухайн шүүгч өөр хүсэлт гаргаагүй бол түүнийг сахилагын хорооны хуралдаанд биечлэн оролцуулна.

*49 дүгээр зүйл. Сахилагын хорооны шийдвэр*

1. Сахилагын хороо сахилагын хэргийг хянан хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж тогтоол үйлдэнэ:

1) сахилагын шийтгэл ногдуулах;

2) сахилагын хэргийг хэрэгсэхгүй болгох;

3) шүүгчийг эрүүгийн хариуцлагад татуулахаар холбогдох баримт сэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

2. Сахилагын хороо тогтоолоо сахилагын хэрэг үүсгэсэн байгууллага, албан тушаалтанд болон шийтгэл хүлээсэн шүүгчид шийдвэр гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор хүргүүлнэ.

3. Шүүгч сахиагын шийтгэл ногдууцсан сахиагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Ерөнхий зөвлөлд гомдол гаргаж болно.

4. Ерөнхий зөвлөлд гомдлыг хүлээн авснаас хойш нэг сарын дотор хянан шийдвэрлэнэ. Ерөнхий зөвлөл хуралдаанаараа сахиагын хэргийг хянан хэлэлцээд сахиагын хорооны шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгож сахиагын хэргийг дахин шалгуулж шийдвэрлүүлэх буюу хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргана.

5. Шүүгчээс огцруулах тухай сахиагын хорооны шийдвэрийг Ерөнхий зөвлөлд, Ерөнхийлөгч эс зөвшөөрч сахиагын бусад шийтгэл ногдуулах үндэслэлтэй гэж үзсэн бол Ерөнхий зөвлөлд энэ хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан шийтгэлийн аль тохирохыг ногдуулана.

*50 дугаар зүйл. Сахиагын шийтгэлгүйд тооцох*

Шүүгч сахиагын шийтгэл хүлээсэн едрөөс эхлэн нэг жилийн дотор сахиагын шийтгэл дахин хүлээгээгүй бол түүнийг сахиагын шийтгэлгүйд тооцно.

*51 дүгээр зүйл. Шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл*

1. Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлийн санал болгосноор дараахь үндэслэлээр шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлнө:

1) өөрөө хүсэлт гаргасан;

2) өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн өөр ажил, албан тушаалд сонгосон буюу томносон;

3) биеийн эрүүд мэндийн байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

4) хуульд зааснаар тэтгэвэрт гарах насанд хүрсэн;

5) мэргэшлэлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй тухай дүгнэлтийг Ерөнхий зөвлөлд гаргасан;

6) шүүгчийг орлон ажиллах хугацаа дууссан.

2. Ерөнхий зөвлөл энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шүүгчийг чөлөөлүүлэх тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд Улсын дээд шүүхийн шүүгчийг чөлөөлүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд урьдчилан танилцуулсан байна.

*52 дугаар зүйл. Шүүгчийг огцруулах*

1. Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлийн санал болгосноор дараахь үндэслэлээр шүүгчийг огцруулна:

1) шүүгчээс огцруулах тухай сахиагмын хорооны шийдвэрийг Ерөнхий зөвлөл зөвшөөрсөн;

2) сахиагмын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахиагмын шийтгэл дахин хүлээсэн;

3) шүүгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон.

2. Ерөнхий зөвлөл шүүгчийг огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд Улсын дээд шүүхийн шүүгчдийг огцруулах тухай саналыг Улсын Их Хуралд урьдчилан танилцуулсан байна.

3. Ерөнхийлөгч шүүгчийг чөлөөлүүлэх болон огцруулах тухай Ерөнхий зөвлөлийн саналыг хүлээн авснаас хойш нэг сарын дотор шийдвэрлэнэ.

### 53 дугаар зүйл. Шүүхийн тамгын газар, хэлтэс

1. Шүүхийн тамгын газар Улсын дээд шүүх, Ерөнхий зөвлөлийн ажлын байгууллага бөгөөд шүүх, түүний байгууллага, ажилтны өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах үүрэгтэй.

2. Шүүхийн тамгын газар хуулийн этгээд байна. Соёмбо бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

3. Аймаг, нийслэлийн шүүх, сум бузуу сум дундын, дүүргийн шүүх, дагисан шүүхийн ажиллах нөхцөлийг хангах үүрэг бүхий шүүхийн тамгын хэлтсийг Ерөнхий зөвлөлийн шийдвэрээр аймаг, нийслэлд байгуулж ажилуулна.

4. Шүүхийн тамгын газар, хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны журмыг Ерөнхий зөвлөл тогтооно.

### 54 дүгээр зүйл. Шүүхийн тамгын газрын даргын бүрэн эрх

1. Шүүхийн тамгын газрын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Ерөнхий зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж, түүний шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2) Шүүхийн тамгын газрын ажилтнуудыг томлох, чөлөөлөх;

3) Шүүхийн тамгын хэлтсийн даргыг аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор Ерөнхий зөвлөлд танилцуулан томлох, чөлөөлөх;

4) бусад бүрэн эрх.

2. Шүүхийн тамгын газрын даргыг Ерөнхий зөвлөлийн гишүүн орлохгүй.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### *Шүүхийн байгууллага, ажилтан*

#### *55 дугаар зүйл. Шүүхийн судалгааны төв*

Улсын зөв шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайл-  
бэрлэхэд хууль зүйн онолын асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн  
тоо бүртгэл, практикийг нэгтгэн дүгнэж санал гаргах үүрэг бү-  
хий шүүхийн судалгааны төв ажиллана.

#### *56 дугаар зүйл. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга*

1. Бүх шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн  
дарга ажиллана.

2. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдаа-  
ны зохион байгуулалтын бэлтгэл хангах, тэмдэглэл хөтлөх зэрэг  
хуульд заасан болон шүүгчээс хүлээлгэсэн үүргийг биелүүлнэ.

#### *57 дугаар зүйл. Шүүхийн хуяг*

1. Шүүхэд шүүх хуралдааны дэг журам сахнуулах, шүүгч,  
бусад оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүхэд дуудсан  
этгвэдийг албадан ирүүлэх болон хуульд заасан бусад бүрэн  
эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий хуяг ажиллана.

2. Хуягийн бүрэн эрх, үйл ажиллагааны журмыг хуулиар  
тогтооно.

3. Хуяг нь албаны дүрэмт хувцас, бие хамгаалах тусгай хэ-  
рэгсэл хэрэглэх эрхтэй.

#### *58 дугаар зүйл. Шүүхийн тогтоол гүйцэтгэгч*

1. Шүүхийн тамгын газар, хэлтэст тогтоол гүйцэтгэх алба  
ажиллана.

2. Шүүхийн тогтоол гүйцэтгэгч ялгах тэмдэг, албаны дүрэмт  
хувцас, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй.

3. Тогтоол гүйцэтгэгч шүүх хуралдааны нарийн бичгийн  
даргын үүргийг гүйцэтгэж болно.

4. Шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн бүрэн эрх, үйл ажил-  
лагааны журмыг хуулиар тогтооно.

#### *59 дугаар зүйл. Шүүхийн болон шүүхийн байгууллагын ажилтныг томлох, чөлөөлөх*

Шүүхийн болон шүүхийн байгууллагын ажилтныг тухайн  
шатын шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн шүүхийн там-  
гын газар, хэлтсийн дарга томилж, чөлөөлнө.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### *Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгаа*

*60 дугаар зүйл. Шүүхийн төсөв, ажиллах нөхцөл*

1. Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

2. Шүүхийн төсвийг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгана. Шүүхийн төсөв шүүх эрх мэдлийг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байвал зохино.

3. Шүүхийг байнга болон нүүдэллэн ажиллах байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, ажилтныг орон байраар хангах зэрэг шүүх, шүүгч үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн захиргааны байгууллага бүх талын дэмжлэг үзүүнэ.

*61 дүгээр зүйл. Шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс үл нөлөөлөх*

Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс орлоцох, нөлөөлэхийг хориглоно.

*62 дугаар зүйл. Шүүгчийн уас төрийн эрх*

1. Шүүгч өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, мэргэжлээ дээшлүүлэх, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор мэргэжлийн олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх чөлөө эдлэнэ.

2. Шүүгч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

3. Шүүх, шүүхийн байгууллагад улс төрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Шүүгчийн албан тушаал хаших хугацаанд түүний улс төрийн намын гишүүчлэлийг түдгэлзүүнэ.

*63 дугаар зүйл. Шүүгчийн халдашгүй эрх*

1. Шүүгчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчлалснаас бусад тохиолдолд Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр албадан



саатуулах, цагдан хорих, баривчлах, гэр, албан тасалгаа болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

2. Шүүгчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчласан буюу эрүүгийн хариуцлагад т тэх хангаалтай үндэслэл тогтоовол энэ тухай Ерөнхий зөвлөлд 48 цагийн дотор мэдэгдэнэ.

3. Шүүгчийг эрүүгийн хариуцлагад татах хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл зөвшөөрөл авах хүсэлтийг Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид тавина.

4. Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлийн хүсэлтийг хүлээн аваад шүүгчийг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгох, эсэх асуудлыг 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5. Шүүгчийг эрүүгийн хариуцлагад татсантай холбогдуулан түүний бүрэн эрхийг Ерөнхийлөгч түдгэлзүүлж болно.

6. Шүүгчийг албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, гэр, албан тасалгаа болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийх шаардлагатай бол энэ зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасан журмаар зөвшөөрөл авна.

*64 дүгээр зүйл.* Шүүгчийн цалин хөлс, дархан эрх, зараат бус байдалын бусад баталгаа

1. Хуульд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг ажлаас чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

2. Шүүгчийн цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно. Улсын дээд шүүхийн шүүгч тэрийн өндөр албан тушаалтын зэрэг дээд тохирсон цалин авна. Бусад шүүгчийн цалинг Улсын дээд шүүхийн шүүгчийн цалинтай зохист харьцаатай байхаар тооцож тогтооно. Шүүгчийн цалинг бууруулж болохгүй.

3. Шүүгч албан дайчлагавнаас чөлөөлөгдөнө.

4. Шүүгч цэргийн жинхэнэ албанд татагдвал Ерөнхийлөгч шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлж, албан тушаалыг нь хэвээр хадгална.

5. Шүүгч албан үүргээ гүйцэтгэж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр аадсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг олгоно.

6. Шүүгч албан үүргээ гүйцэтгэж байхдаа бусдын нөлөөгөөр амь насаа аадсан тохиолдолд түүний эр гэрт нь хохирогчийн

3 жилийн үндсэн цаалнтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцаатгүй тусламж олгоно.

7. Энэ зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан тэтгэвэр, тэтгэмж, үндсэн цаалигчийн зөрүү, буцаатгүй тусламжийг улсын төсвөөс олгож, хуульд заасан тохиолдолд хохиралыг гэм буруутай этгээдээр нохон төлүүнэ.

8. Шүүн таслах ажиллагааны явцад шүүгчийн гаргасан алдааны улмаас учирсан хохиралыг төр хариуцна.

9. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч гэдвэлд зорчих, байх хугацаандаа дипломат эрх имба, дархан эрх эдэлнэ.

65 дугаар зүйл. Шүүхийг үл хүндэтгэгчид хүлээлгэх хариуцлага

Шүүхийг үл хүндэтгэгчид хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын  
дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын  
Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

1993 оны 2 дугаар  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

1993 оны 2 дугаар  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Шүүхийн тухай хууль, батлагдсантай холбогдуулан «БНМАУ-ын шүүхийн байгууламжийн хууль, түүнд холбогдох бусад дүрмийг батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигийг баталсан БНМАУ-ын 1978 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуулийг хүчингүй болсонд тооцугай.

Монгол Улсын Их Хурлын  
дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын  
Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН НИЯГТААН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### *Нийтлэл үндэслэл*

##### *1 дүгээр зүйл. Хуулийн зорилт*

Энэ хуулийн зорилт нь аж ахуйн нэгж, байгууллагаас нягтлан бодох бүртгэл хөтөлөх, тайлан тэнцэл гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### *2 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж*

1. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас сөр журам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### ХОЕРДУГААР БҮЛЭГ

#### *Нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл*

##### *3 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэл хөтөлөх*

1. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, түүний эх үүсвэр болон үйлдвэрлэл, ажил, үйлчилгээнийхээ санхүүгийн үр дүн, мөнгөн хөрөнгийн хөдөллийн талаар нягтлан бодох бүртгэл заавал хөтөлж, тайлан тэнцэл гаргана.

Нягтлан бодох бүртгэлд анхан шатны бүртгэлийн албан ёсны баримт бүрдүүлэх, түүнийг үндэслэж дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтөлөх, тайлан тэнцэл гаргах үйл ажиллагаа хамаарна.

2. Аж ахуйн нэгж, байгууллага нь нягтлан бодох бүртгэлийг энгийн эсхүл давхар бичилтийн хэлбэрээр хөтөлнө. Харилцагч санхүүгийн байгууллаагатай тохиролцсон аж ахуйн нэгж, байгууллага нь энгийн хэлбэрээр, бусад аж ахуйн нэгж, байгууллага давхар бичилтийн хэлбэрээр нягтлан бодох бүртгэлийг хөтөлнө.

##### *4 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн ажлын зохион байгуулалт*

1. Нягтлан бодох бүртгэлийн маягт, аргачлал нь анхан шатны ба нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцлийн маягт, заввар, нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, түүнийг хэрэглэх заввар зэргээс бүрдэнэ.

2. Аж ахуйн нэгж, байгууллага заавал хөтлөх нягтлан бодох бүртгэлийн нийтлэг маягт, түүнийг хөтлөх аргачлалыг Сангийн сайд батална. Аж ахуйн нэгж, байгууллага нь эдгээр маягт аргачлалаас гадна дотооддоо мөрдөх мэдээ, тайлан, анхан шатны бүртгэлийн маягтыг боловсруулан хэрэглэж болно.

3. Нягтлан бодох бүртгэлийн маягт, аргачлал дараахь шаардлагыг хангасан байна:

1) улсын эдийн засгийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, өмч эзэмшигчээс үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх, удирдлагын шийдвэр гаргах, хяналт тавих бололцоотой байх;

2) маягтын үзүүлэлт нь улсын нэгдсэн мэдээллийн шаардлага хангасан товч, тодорхой, ойлгомжтой, агуулга нь давхардаагүй, оновчтой загвараар зохиогдсон байх;

3) олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байх;

4) нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлан тэнцэл гаргах албан тушаалтан, хугацааг тодорхой заасан байх.

5 *дугаар зүйл.* Тайлан тэнцлийн бүрэлдэхүүн, түүнийг баталгаажуулах, тушаах

1. Аж ахуйн нэгж, байгууллагын тайлан тэнцэл нь хөрөнгө, түүний эх үүсвэр, аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, мөнгөн хөрөнгийн хөдөллийг харуулсан тэнцэл, хавсралт тайлангаас бүрдэнэ.

Тайлан тэнцэлд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн үр дүнд хийсэн шинжилгээ, дүгнэлтийг хавсаргасан байна.

2. Аж ахуйн нэгж, байгууллага нь тайлан тэнцлээ оны эхнээс өссөн дүнгээр улирал бүр гаргаж, харилцагч санхүүгийн байгууллагаар хянуулж баталгаажуулна.

Зохих хууль тогтоомжийн дагуу Сангийн сайдын зөвшөөрлөөр улсын бүртгэлд бүртгэгдсэн нягтлан бодох бүртгэл, хяналтын нтгэмжлэгдсэн байгууллагаас аж ахуйн нэгж, байгууллагын тайлан тэнцлийг баталгаажуулсан болон санхүүгийн байгууллага давхар баталгаажуулахгүй.

Баталгаажуулсан тайлан тэнцлийн хураангуйг хэвлэн нийтэлж болно.

3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэ зүйлийн 2 дахь

хэсэгт заасны дагуу баталгаажуулсан тайлан тэнцээдээ үндэслэн Улсын татварын алба болон хувьцаа эзэмшигч, хувь нийлүү-дэгчтэй эцсийн тооцоо хийнэ.

4. Баталгаажуулсан тайлан тэнцэлийг харилцагч санхүүгийн байгууллагад тушаана. Энэхүү тайлан тэнцэлийг статистик, банкны байгууллага шаардан авч болно.

5. Аж ахуйн нэгж, байгууллага улирлын тайлан тэнцлээ дараа улирлын эхний сарын 20, жилийн эцсийн тайлан тэнцлээ дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор тус тус гаргаж тушаана.

*6 дугаар зүйл.* Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж

1. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг, мөнгөөр илэрхийлэгдсэн байна.

2. Аж ахуйн нэгж, байгууллага нь гадаад валютээр гүйлгээ хийсэн бол уг валютыг тухайн үед мөрдөж байгаа Монголбанкнаас тогтоосон ханшаар төгрөгт шилжүүлэн нягтлан бодох бүртгэлд тусгана.

*7 дугаар зүйл.* Хөрөнгийн үнэлгээ

1. Аж ахуйн нэгж, байгууллага хөрөнгөө түүнийг олж бэлтгэсэн, худалдаж авсан үнэ, барьж байгуулсан өртгөөр нь нягтлан бодох бүртгэлд тусгана.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцээд тусгасан үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үнэлгээг эрх бүхий байгууллагаас тусгай шийдвэр гаргаагүй бол жилийн дундуур өөрчлөхгүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл зөвхөн жилийн эцэст дахин үнэлж болно.

3. Төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан байдлаар хувь оролцсон аж ахуйн нэгж, байгууллагын үрэгдүүлж, дутагдууласан хөрөнгийн тооцоог тухайн үеийн зах зээлийн үнээр хийнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

*Нягтлан бодох бүртгэлийн ажлыг эрхлэх, удирдах зохицуулах*

*8 дугаар зүйл.* Нягтлан бодох бүртгэлийн байгууллага, түүний үүрэг

1. Нягтлан бодох бүртгэлийн ажлыг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар улсын хэмжээнд нэг мөр хангах үүргийг

Сангийн сайд хүлээнэ. Энэ зорилгоор Сангийн яамны бүтцэд нягтлан бодох бүртгэлийн арга зүйн удирдлагыг эрхлэх нэгж (газар, хэлтэс) байж болно.

2. Нягтлан бодох бүртгэлийг зохион байгуулах үүрэг, харуцлагыг аж ахуйн нэгж, байгууллаагын эрх баригч хүлээнэ.

3. Аж ахуйн нэгж, байгууллаага нь нягтлан бодох бүртгэлийг мэргэжлийн буюу мэргэшсэн нягтлан бодогчоор гүйцэтгүүлнэ.

4. Эрдэмтэд, нягтлан бодох бүртгэл, тооцооны мэргэшсэн хүмүүс, өмчийн бүх төрөлд хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллаагын төлөөлөгчдөөс бүрдсэн Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн орон тооны бус зөвлөлийг Сангийн сайдын дэргэд түүний тушаалаар байгуулна. Уг зөвлөл нягтлан бодох бүртгэлийн маягт, аргачлалыг боловсронгуй болгох, нягтлан бодогчдыг батлах, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл, тайлангийн ажлын зохион байгуулалтыг сайжруулахад туслах үүрэгтэй.

*9 дугаар зүйл.* Нягтлан бодогчийн мэргэжил, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох

1. Нягтлан бодогчийн мэргэжлийг мэргэжлийн сургалтын байгууллаага олгоно. Аж ахуйн нэгж, байгууллаага нь гагцхүү шинжлэх ухаан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллаага, Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр нягтлан бодогчийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж болно.

2. Мэргэжлээрээ хоёроос доошгүй жил ажилласан нягтлан бодогчийг өөрийнх нь хүсэлтийн дагуу Сангийн яам, Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн орон тооны бус зөвлөл тусгай хөтөлбөрөөр шалгаж, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх түүнд олгоно.

3. Төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан байдлаар хувь оролцсон аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн ажлыг гагцхүү мэргэшсэн нягтлан бодогч удирдана.

*10 дугаар зүйл.* Нягтлан бодогчийн бүрэн эрх

Нягтлан бодогч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) тухайн аж ахуйн нэгж, байгууллаагынхаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажлыг зохион байгуулах, хяналт шалгалт хийх, арга зүйн зөвлөмж өгөх;

2) баталсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан тэнцэл гарган аж ахуйн нэгж, байгууллаагын

удирдлага, хувь нийлүүлэгч ба хувьцаа эзэмшигчийг үнэн зөв мэдээлэлээр хангах;

3) санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, хууль тогтоомжийн бусад актыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хэрэгжүүлж, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих, биелүүлэхийг холбогдох ажилтнуудаас шаардах;

4) хууль тогтоомжийн дагуу тавьсан шаардлагыг нь эсэргүүцэх буюу хэрэгжүүлээгүй тохиолдолд энэ тухай холбогдох байгууллагад мэдэгдэх;

5) санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжид харшлах үйлдэл гүйцэтгэхийг бичгээр шаардаж гүйцэтгүүсэни бол үүнээс үүсэх хариуцлагыг нягтлан бодогч хүлээхгүй;

6) өсрийн ажил, үүргийнхээ дагуу шууд хяналт тавьдаг албан тушаалын ажлыг хавсран гүйцэтгэхгүй байх.

### *11 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэл, хяналтын итгэмжлэгдсэн байгууллага*

1. Нягтлан бодох бүртгэл, хяналтын итгэмжлэгдсэн байгууллага (цаашид «итгэмжлэгдсэн байгууллага» гэх) нь үйл ажиллагааныхаа орлогоор бүрэн санхүүжиж бие даан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд байна.

2. Итгэмжлэгдсэн байгууллагад зөвхөн мэргэшсэн нягтлан бодогч ажиллах бөгөөд энэ байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа санхүүгийн үр дүнг тайлан тэнцвэлд үнэн зөв тусгасан эсэх, нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж байгаа эсэх, татвараа хууль тогтоомжийн дагуу үнэн зөв ногдуулан төсөвт төлсөн эсэхийг үндсэн баримтаар нь шалгаж баталгаажуулах;

2) аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, санхүүгийн нөөцийн байршил, тэдгээрийн ашигlaatын байдалыг шинжилж, хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийсэн эсэх талаар дүгнэлт гаргах;

3) аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн зөвлөлгөө өгөх;

4) аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх. Энэ тохиолдолд тухайн байгууллагын тайлан тэнцлийг уг итгэмжлэгдсэн байгууллага баталгаажуулахгүй;



5) тайлан тэнцлийг буруу баталгаажуулсан буюу нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтөлснөөс учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцах;

6) харилцагч аж ахуйн нэгж, байгууллагын технологийн болон худалдаа, ариажалны нууцыг хадгалах.

3. Итгэмжлэгдсэн байгууллага энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ аж ахуйн нэгж, байгууллагатай зохих хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг тайлан тэнцэлд буруу тусгаснаас үүсэх материалын хариуцлагыг итгэмжлэгдсэн байгууллага хүлээнэ.

4. Итгэмжлэгдсэн байгууллага төрийн байгууллага болон гэрээгээр ажлыг нь гүйцэтгэж байгаа байгууллагынхаа хүлээх үүргийг хариуцаагүй, төрийн байгууллага болон ажлаа гүйцэтгүүлж байгаа байгууллага өөртөө тухайлан хүлээгээгүйгөөс бусад тохиолдолд итгэмжлэгдсэн байгууллагын хүлээх үүргийг хариуцаагүй.

5. Итгэмжлэгдсэн байгууллагын үлгэрчилсэн дүрмийг Сангийн сайд батална.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

12 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөөгүй, тайлан тэнцэл гаргаагүй буюу хугацаа хожимдуулсан, баримт материалыг бүрдүүлээгүй, эсхүл нуун дарагдауулсан зэргээр нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг эсрэгсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол санхүүгийн байгууллага гэм буруутай этгээдэд 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Мэргэшсэн нягтлан бодогч нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл хөтлөх, шаалгах үйл ажиллагаандаа алдаа гаргасан, эсхүл буруу гаргасан тайлан тэнцлийг баталгаажуулсан бол мэргэшсэн нягтлан бодогчийнх нь эрхийг хасах буюу зохих хууль тогтоомжийн дагуу түүнд хариуцлага хүлээлгэнэ.

13 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1993 оны дөрөвдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын  
дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын  
Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

1993 оны 2 дугаар  
сарын 8-ны өдөр

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛЬ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### *Нийтлэл үндэслэл*

#### *1 дүгээр зүйл. Хуулийн зорилт*

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг бэлтгэн явуулахтай холбогдсон зарилцааг зохицуулахад оршино.

#### *2 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомж*

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### *3 дугаар зүйл. Сонгуулийн үндсэн зарчим*

1. Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгчийн сонгууль (цаашид «сонгууль» гэх) хоёр шаттай байна.

2. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролдож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана.

3. Анхан шатны сонгууль бүх нийтийн байна. Санал хураах өдөр өх орондоо байгаа, Монгол Улсын 18 насанд хүрсэн ир-

гөн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гэрэл, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүүлт, үзэл бодол, боловсрол илгавэргүйгээр сонгох эрхтэй. Гарц хүү эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан соолотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ил эдэлж байгаа хувь сонгуульд оролцохгүй.

4) Анхан шатим сонгууль шууд байна. Сонгуульд сонгогч ямар нэг төлөөлөлгүйгээр оролцон саналаа өөрөө гаргаж Ерөнхийлөгчийг сонгоно.

5. Сонгогч саналаа нууцаар гаргана. Сонгогчөөс саналаа төлөөтэй илэрхийлэхэд саад учруулахыг хориглоно.

6. Анхан шатим сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэн түүний бүрэн эрхийг мэдээн зөвшөөрсөн хууль гаргах нь сонгуулийн хоёр дахь шат байна.

4 дүгээр зүйл. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх

1. Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэнэ.

2. Тухайн сонгуульд нэг хүний нэрийг дахин дэвшүүлж болохгүй.

5 дүгээр зүйл. Сонгууль эрхлэн явуулах байгууллага

1. Сонгуулийг улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээр дэх хот, тосгон, хэсгийн хэмжээнд сонгуулийн хөрөөд эрхлэн явуулна.

2. Сонгууль бэлтгэн явуулахад төрийн төв, орон нутгийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжийн дагуу тулалцаа үзүүлнэ.

6 дүгээр зүйл. Сонгууль бэлтгэн явуулах ажлын ил төд байдал

1. Сонгууль бэлтгэн явуулах ажлын ил төд байна. Энэ заалт сонгогч саналаа нууцаар гаргахад хамраахгүй.

2. Төрийн байгууллагын харьяалаа бүхий хөдөл, мэдээллийн байгууллага сонгууль бэлтгэн явуулах ажлын явц, сонгуулийн дүнг олон нийтэд шуурхай мэдээлэх үүрэгтэй.

3. Төв, орон нутгийн сонин хөдөл, мэдээллийн бусад байгууллагын нийтэлсэн мэдээлэл үнэн зөв байвал зөвшөө.

7 дүгээр зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

1. Сонгууль зохион байгуулж явуулахтай холбогдсон даргах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

1) нэр дэвшигчийн намтар, нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, ажиглагчийн үнэмлэх, саналын хуудас, сонгогчийн шилжүүлэг, сонгуулийн дүн, мэдээний маягт хэвлэх, сонгуулийн хороодын тамга, тэмдэг хийлгэх зардал;

2) сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилгоотын зардал;

3) Улсын Их Хурлаас тогтоосон бусад зардал.

2. Улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

3. Сонгуулийн хорооны гишүүний тус хороонд ажилласан хугацааны хөлсийг сарын дундаж цалингийн хэмжээгээр тооцож ажлын газар, байгууллагаас нь олгоно. Тэтгэвэрт байгаа болон эрхэлсэн ажилгүй хүн сонгуулийн хорооны гишүүнээр ажиллавал гүйцэтгэсэн ажлын хэмжээг харгалзан тухайн сонгуулийн хорооны саналыг үндэслэн орон нутгийн төсвөөс зохих хөлс олгоно.

4. Сонгуулийн хороодын ажиллах, санал хураах байрыг улс, орон нутгийн төсөвт болон төрийн өмчит байгууллагууд үнэ хөлсгүй, хувийн өмчит байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гаргаж өгнө.

Сонгуулийн хороодыг ажлын байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна.

5. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам нэр дэвшигчийг бүртгүүлснээс хойш 5 хоногийн дотор сонгуулийн зардлын сан байгуулж банкинд данс нээж, Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэж нийтэд зарлана. Энэ дансанд тухайн нэр дэвшигчийн өөрийн болон нэр дэвшүүлсэн намын хөрөнгө, талархан дэмжигч нам, байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж мөн дансаар дамжуулан зарцуулна.

Талархан дэмжигч нам, байгууллага, иргэд сонгуульд зориулж зөвхөн мөнгөн хандив өргөж болох бөгөөд түүнийг сонгуулийн зардлын сангийн дансанд оруулна. Уг данснаас гадуур сонгуульд зориулж хандив авах, өгөх, зарцуулахыг хориглоно.

Төсөвт ба төрийн өмч оролцсон байгууллага (төрийн өмчийн хэсгээс нь), гадаадын байгууллага (хамтарсан байгууллагын гадаадын оролцогч), иргэн, харьяалаагүй хүнээс сонгууль бэлтгэн явуулах хугацаа (сонгууль зарласнаас эхлээд дуустал)-нд хандив авч болохгүй.

Сонгууль бэлтгэн явуулах хугацаанд тусламжийн эд хөрөнгийг борлууж сонгуульд зарцуулахыг хориглоно.

Нэр дэвшигчийг талархан дэмжигч нам, байгууллага, нргөдвээс сонгуульд зориулж өргөсөн хандиами нийт хэмжээ 10 сая төгрөгөөс хэтэрч болохгүй.

6. Сонгуулийн зардлыг санг нэр дэвшигчийг сурталчлах, сонгогчидтой уулзах, хурал цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажлалтын бичиг хэрэг, шуудан, холбоо, унааны болон адбан томилолтын зэрэг Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан заавраар зөвшөөрсөн бусад зардлыг сангүүжүүлэхэд зарцуулна.

Сонгуулийн зардлыг сан бий болгох, зарцуулах, тайлагнах журмыг Сонгуулийн ерөнхий хороо Сангийн яамтай зөвшилцон батална.

7. Тухайн нэр дэвшигчийн хувьд анхан шатны сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс эхлэн түүний сонгуулийн зардлыг сангийн дансны хөдөлгөөнийг зогсооно.

8. Нэр дэвшүүлсэн нам болон сонгуульд хамтарч нэр дэвшүүлсэн намуудыг төлөөлөх байгууллага сонгуулийн зардлыг сангийн зарцуулалтын тайланг дансны хөдөлгөөн зогсоосон өдрөөс хойш нэг сарын дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ. Сонгуулийн ерөнхий хороо уг тайланг хянан үзэж сонгууль дууссан өдрөөс хойш гурван сарын дотор дүнг төрний төв хэвлэлд нийтлэнэ.

9. Нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг сангийн дансанд үлдсэн хөрөнгийг улсын орлого болгоно. Сонгуулийн зардлыг сангийн данснаас гадуур, зориулалтын бусаар зарцуулсан хөрөнгийг нөхөн төлүүлнэ.

*8 дугаар зүйл. Сонгуулийн эрхийг хангах хууль зүйн баталгаа*

1. Төрний байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажлалтан оролцохыг хориглоно.

2. Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгвээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3. Сонгогчдоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд буюу сонгуулийн хороо, түүний гишүүнээс үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад хийх, сүсэг бишрэлийг далимдуулах, бусдын нэрийн өмнөөс сонгуульд оролцох, санал худалдаж авах, санал хураах, тоолох ажлыг санаатай саатуулах зэргээр сонгуулийн

хүрээлэн төгсөхөд зөрчсөнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал гэм буруутай өтгөөдөд шүүх 500—10000 төгрөгийн торгууль ногдуулна.

4. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан үүргөө биелүүлээгүй албан тушаалтанд сахиагмын хариуцлага хүлээлгэхээргүй байвал шүүх түүнд 200—2000 төгрөгийн торгууль ногдуулна.

5. Энэ хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн үйлдэлэ зогсоох талаар сонгуулийн хорооны тавьсан шаардлагыг биелүүлээгүй нэр дэвшигч, албан тушаалтан, намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтанд шүүх 500—10000 төгрөгийн торгууль ногдуулна.

6. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 4, 17 дугаар зүйлийн 3, 29 дүгээр зүйлийн 2, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй Засаг дарга, төсөвт байгууллагын эрх баригчид сахиагмын хариуцлага хүлээлгэхээргүй байвал шүүх түүнд 1000—5000 төгрөгийн торгууль ногдуулна.

7. Энэ хуулийн 28 дугаар зүйлийн 2, 5 дахь хэсгийн заалтыг зөрчсөн хөжлөл, мэдээллийн байгууллаагад шүүх 3000—50000 төгрөгийн торгууль ногдуулна.

8. Энэ хуулийн 27 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал гэм буруутай өтгөөдөд шүүх 500—10000 төгрөгийн торгууль ногдуулна.

9. Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн сонгуулийн хорооны гишүүнд шүүх 1000—5000 төгрөгийн торгууль ногдуулна.

10. Сонгуулийн хороонд ашиглахаар томилогдсон иргэн үүрэгт ажлаа биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол шүүх түүнд 1000—5000 төгрөгийн торгууль ногдуулна.

11. Энэ зүйлэд заасан дагуу хариуцлага хүлээсэн байгууллага, албан тушаалтан, иргэн холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу шүүхийн шийдвэрийг данж заадагш буюу гэмдол гаргаж болно.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

*Сонгууль зарлах, сонгуулийн хэсэг байгуулах*

9 дүгээр зүйл. Сонгууль зарлах

Сонгуулийг санал зургах өдрөөс 75-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана.

*10 дугаар зүйл. Сонгуулийн хэсэг, түүнийг байгуулах*

1. Сонгогчдын санал хурааж тоолох зорилгоор сонгуулийн хэсгийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал хураах өдрөөс 70 хоногийн өмнө байгуулж, хэсгийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг зарлана. Харин иргэд бөөнөөрөө шилжин суурьшсан зэрэг онцгой тохиолдолд сонгуулийн хэсгийг санал хураах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө байгуулах буюу шилжүүлэн байршуулж болно.

2. Сонгуулийн нэг хэсэг нь 2000 хүртэл, харин нийслэл болох бусад хотод 6000 хүртэл сонгогчтой байж болно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**

*Сонгууль эрхлэн явуулах байгууллага, түүний бүрэн эрх*

*11 дүгээр зүйл. Сонгуулийн хороо*

1. Сонгууль бэлтгэн явуулах ажлыг дараахь байгууллагууд эрхэлнэ:

- 1) Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо;
- 2) сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо;
- 3) сонгуулийн хэсгийн хороо.

2. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо нь сум, түүнтэй адилгах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар хороог байгуулж ажиллуулна.

3. Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нэр дэвшигчийн талаар сурталчлагаа хийхийг хориглоно.

*12 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо, түүний бүрэн эрх*

Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо (цаашид «Сонгуулийн ерөнхий хороо» гэх) нь үйл ажиллагаагаа бие даан явуулах бөгөөд түүний бүрэн эрх, бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага, томилогдох хугацаа нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар тодорхойлогдоно.

*13 дугаар зүйл. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо, түүний бүрэн эрх*

1. Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэлийн дүүрэгт сонгууль бэлтгэн явуулах ажлыг зохион байгуулах, сонгуулийн дүнг нэгтгэн Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх зорилгоор

аймаг, нийслэлийн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг харгалзан санал хураах өдрөөс 65 хоногийн өмнө сонгуулийн нутаг дэвсгэрийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулаж нийтэд мэдээлнэ.

Сонгуулийн нутаг дэвсгэрийн хорооны бүрэлдэхүүний тоог ажлын хэмжээ, намын төлөөллийг харгалзан Сонгуулийн ерөнхий хороо тогтооно.

2. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) сонгууль баалтган явуулах ажлыг төлөвлөн зохион байгуулах;

2) сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, нэг мөр сахин биелүүлэх явдлыг хангах, сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар болон хэсгийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах;

3) сонгууль баалтган явуулах асуудлаар тухайн нутаг дэвсгэрт байгаа төрийн зохих шатны байгууллаагын үйл ажиллагааг зохицуулах;

4) сонгууль баалтган явуулах асуудлаар сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар болон хэсгийн хороо, тухайн нутаг дэвсгэрийн төрийн зохих шатны байгууллаагын удирдагчдын мэдээлэл сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

5) сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргаан бүхий бусад ергэдэл, гомдлыг хянан шийдвэрлэх;

6) санал хураалтын дүнг сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар болон хэсгийн хороодоос авч нэгтгэн Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх;

7) дахин санал хураах, сонгууль явуулах ажлыг зохион байгуулах;

8) хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх, Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн үүргийг биелүүлэх.

14 дүгээр зүйл. Сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар хороо, түүний бүрэн эрх

1. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо тухайн сум, түүнтэй адилтгах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн санал, намын төлөөллийг харгалзан санал хураах өдрөөс 60 хоногийн өмнө сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар хороог дарга, нарийн бичгийн



дарга, 5 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж нийтэд мэдээлнэ.

2. Сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар хороо тухайн орон нутагт сонгууль бэлтгэн явуулах асуудлаар сонгуулийн нутаг дэвсгэрийн хорооны даалгавраар түүний зохих бүрэн эрхийг төлөөлөн хэрэгжүүлнэ.

15 дугаар зүйл. Сонгуулийн хэсгийн хороо, түүний бүрэн эрх

1. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг харгалзан санал хураах өдрөөс 55 хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороог дарга, нэрийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж нийтэд мэдээлнэ.

Сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо, ажлын хэмжээ, намын төлөөллийг харгалзан сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо тогтооно.

2. Сонгуулийн хэсгийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) сонгуулийн хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал хураах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

2) сонгогчийг шилжүүлэх, шинээр ирсэн сонгогчийг бүртгэх;

3) сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хэмжээнд нэгтгэж шалгах;

4) санал хураах байр, саналын хуудас, хайрцгийг бэлтгэж, сонгогчдын санал хураах ажлыг зохион байгуулах;

5) санал хураалтын дүн гаргаж, сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар хороонд хүргэх;

6) сонгуулийн баримт бичгийг цэгцэлж сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар хороонд хүлээлгэн өгөх;

7) сонгууль бэлтгэн явуулах асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, холбогдох байгууллаагад уламжлах;

8) хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх, сонгуулийн нутаг дэвсгэрийн хорооноос өгсөн үүргийг биелүүлэх.

16 дугаар зүйл. Сонгуулийн хорооны ажлын зохион байгуулалт

1. Сонгуулийн хороод бүрэн эрхийнхээ асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана. Гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол хорооны хуралдааныг хүчин төгөлдөрт тосгнэ.

Сонгуулийн ерөнхий хороо, нутаг дэвсгэрийн болон салбар хорооны дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.

2. Сонгуулийн нутаг дэвсгэрийн болон түүний салбар хороо, түүнчлэн хэсгийн хороо ажлын шаардлага, зардлын хэмжээг харгалзан гишүүдээ үндсэн ажлаас нь түр чөлөөлж ажиллуулах болно.

3. Хуульд зааснаас бусад тохиолдолд сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар болон хэсгийн хорооны шийдвэрийн талаар сонгуулийн нутаг дэвсгэрийн хороонд, сонгуулийн нутаг дэвсгэрийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн ерөнхий хоргойд тус тус гомдол гаргаж болно. Гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хянан шийдвэрлэж харих мэдэгдэнэ.

4. Сонгуулийн хороо сонгууль боолтгүй явуулахтай холбогдсон асуудлаар төр, нам, олон нийтийн зохих шатны байгууллага, албан тушаалтанд зууль ёсны шаардлага тавих эрхтэй бөгөөд тэдгээр байгууллага, албан тушаалтан тухайн шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж харих мэдэгдэнэ.

5. Сонгуулийн хорооны бүрэн эрхийнхөө дотор гаргасан шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрийн төр, нам, олон нийтийн байгууллага, албан тушаалтан биелүүвэх үүрэгтэй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Сонгогчдын нэрийн жагсаалт

17 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт, түүнийг үйлдэх, танилцуулах

1. Сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн хэсэг бүрээр үйлдэж, сонгогчдын тоог сонгуулийн хороодод нэгтгэнэ.

2. Сонгогчдын нэрийн жагсаалтад түүнийг үйлдэх үед сонгуулийн тухайн хэсэгт байнга буюу түр оршин суугаа бүх сонгогчийн нэр, овог, нас, оршин суугаа газрын хаяг, иргэний паспортын болон регистрийн дугаарыг бүртгэнэ. Сонгогч бүр нэрийн нэг жагсаалтад бүртгэгдэнэ.

3. Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга тус тусын нутаг дэвсгэрт оршин суугаа сонгогчдын нэрийн жагсаалтыг хагсийн бүртгэлийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан заягтаар хоёр хувь үйлдэж санаа хураах өдрөөс 50 хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороонд өгнө.

Цагдаа, эмнэлэг, амраат, сувилалын газрын өрх баригчид сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхэд шаардагддаг мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

4. Сонгуулийн хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг санал хураах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу хоёр хувь үйлдэж сонгуулийн хэсгийн хорооны дарга гарын үсгээ зурж, санал хураах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө, зарим эмнэлэг, амралт, сувилалын газарт 7 хоногийн өмнө нл тавьж сонгогч-дод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

18 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалтын талаар гомдол гаргах

1. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн байвал сонгогч тухайн сонгуулийн хэсгийн хороонд гомдол гаргах эрхтэй.

2. Сонгуулийн хэсгийн хороо уг гомдлыг хүлээн авснаас хойш ажамн 3 өдрийн дотор хянан үзэж сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлт оруулах буюу гомдлыг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргаж хариу мэдэгдэнэ. Сонгогч уг шийдвэрийг эс зөвшөөрвэл гомдлоо шүүхэд гаргана.

19 дүгээр зүйл. Сонгогч шилжих

Сонгогч санал хураах өдрөөс өмнө сонгуулийн өөр хэсэгт шилживал сонгуулийн хэсгийн хорооноос шилжүүлэг ааг сонгогч-дын нэрийн жагсаалтаас хасуулаж, очсон газрынхдаа сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгүүлэнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ

*Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх*

20 дугаар зүйл. Нэр дэвшүүлэх хугацаа

Нэр дэвшүүлэх ажлыг сонгууль зарласнаас хойш 7 хоногийн дараа өхөлж 15 хоногийн хугацаанд дуусгана.

21 дүгээр зүйл. Нам дангаар нэр дэвшүүлэх

Улсын Их Хуралд суудал бүхий нам (өнэ хуульд цаашид «нам» гэх)-ын төв байгууллага Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэнэ. Намын төв байгууллагад тухайн намын их хурал, түүний чөлөө цэгт ажлаах бага, бүгд хурал, тэдгээртэй адилтгах байгуу-лага орно.

22 дугаар зүйл. Намууд хамтарч нэр дэвшүүлэх

1. Намууд хамтарч нэр дэвшүүлэхдөө намын төв байгуулла-

гуудынхаа хуралдаанаар сонгуульд хамтарч оролцох тухай асуудлыг шийдвэрлэж, гэрээ байгуулна.

2. Сонгуульд хамтарч оролцох тухай гэрээнд талуудын харилцан хүлээх эрх, үүрэг, хамтарсан намуудыг сонгуульд төлөөлөх байгууллага, түүний удирдах бүрэлдэхүүнд орсон хүмүүсийн овог, нэр, албан тушаал, сонгуулийн зардлын санд талуудаас оруулах хөрөнгийн хувь хэмжээ, тохиролцсон бусад зүйлийг заасан байвал зохино.

Гэрээнд сонгуульд хамтарсан намуудын дарга нар гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.

3. Хамтарсан намууд сонгуульд төлөөлөх байгууллаагынхаа шийдвэрээр Ерөнхийлөгчид нэр дэвшүүлнэ.

4. Сонгуульд хамтарч оролцох тухай гэрээ байгуулсан нам Ерөнхийлөгчид дангаараа нэр дэвшүүлэх болон сонгуулийн зардлын сан байгуудж болохгүй.

5. Намууд сонгуульд хамтарч оролцох тухай гэрээ, Ерөнхийлөгчид хамтарч нэр дэвшүүлсэн шийдвэрээ цуцалбал Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэлээс хасна.

23 дугаар зүйл. Нэр дэвшигч, түүнийг бүртгэх

1. Сонгуулийн ерөнхий хороонд албан ёсоор бүртгүүлж, үнэмлэх авсан хүнийг Ерөнхийлөгчид нэр дэвшигч гэж үзнэ.

2. Нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хороо сонгууль зарласнаас хойш 25 хоногийн дотор бүртгэн үнэмлэх олгоно.

3. Намын төв байгууллага болон хамтарсан намуудыг сонгуульд төлөөлөх байгууллага Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх тухай шийдвэрээ нэр дэвшигчийн бичгээр өгсөн зөвшөөрөл, Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд үзэл баримтлалаа тодорхойлсон мөрийн хөтөлбөр, Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон заагарын дагуу үйлдсэн намтар, төрсний гэрчилгээ (хэрэв төрсний гэрчилгээ байхгүй бол Монгол Улсын уугуул иргэн болохыг тодорхойлсон баримт бичиг), сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан тухай сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, эмнэлгийн дүгнэлт бүрдүүлсэн байвал зохино.

Нэр дэвшигчийг бүртгэхдээ баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэх, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэхийг нягтлан шалгана.

4. Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэснээс хойш ажлын 3 өдрийн дотор нэр тухай нийтэд мэдээнэ.

24 дүгээр зүйл. Нэр дэвшүүлсэн шийдвэрийг хүчингүй болгох, нэр дэвшигчийг татан гаргах

1. Нэр дэвшигч өөрөө татгалзах буюу нам болон сонгуульд хамтарсан намууд нэр дэвшигчээ татан гаргах, түүний оронд өөр хүнийг нэр дэвшүүлэх эрхтэй.

Нам болон сонгуульд хамтарсан намууд энэ тухай шийдвэрээ Сонгуулийн ерөнхий хороонд нэн даруй мэдэгдэнэ. Нэр дэвшсэнийг хүчингүйд тооцсон тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр, нэр дэвшигч өөрөө татгалзсан, нам болон сонгуульд хамтарсан намууд өөрийн нэр дэвшигчийг татан гаргасан тухай Сонгуулийн ерөнхий хороо нийтэд мэдээлнэ.

2. Нам болон сонгуульд хамтарсан намууд нэр дэвшигчээ татан гаргаснаа санал хураах өдрөөс 21 хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдээгүй бол татан гаргасан нэр дэвшигчийн оронд өөр хүнийг нэр дэвшүүлэх эрхгүй.

### 25 дугаар зүйл. Нөхөн нэр дэвшүүлэх

Нэр дэвшигч нас барсан, түүнчлэн энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан хугацааны өмнө нам болон сонгуульд хамтарсан намууд нэр дэвшигчээ татан гаргасан тохиолдолд тухайн нам болон сонгуульд хамтарсан намууд санал хураах өдрөөс 18 хоногийн өмнө өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлж Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлж болно.

### 26 дугаар зүйл. Нэр дэвшигчид туслах

1. Нэр дэвшигчийн сонгуулийн бэлтгэл ажил, сурталчилгааг улс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий намын сонгууль эрхэлсэн байгууллагыг нэр дэвшүүлсэн нам (хамтарч нэр дэвшүүлсэн намуудын хувьд тэдгээрийг сонгуульд төлөөлөх байгууллага) байгуулж Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэнэ.

2. Намын сонгууль эрхэлсэн байгууллагын удирдагч болон ажилтныг Сонгуулийн ерөнхий хороо бүртгэж үнэмлэх олгоно.

### 27 дугаар зүйл. Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

1. Нэр дэвшигч хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өөрийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ухуулга, сурталчилгаа хийх, холбогдох байгууллагаас зохих журмын дагуу шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.

2. Шаардлагатай үед нэр дэвшигчийг хамгаалалтад авна. Нэр дэвшигчийн хамгаалалтын зардлыг улсын төсвөөс гаргана.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрөлгүйгээр (түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь явдал ба-

римтгайгаар баривчлалснаас бусад тохиолдолд) эрүүгийн хариуц-  
лагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих,  
түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, ором  
байр, албан тасалгаа, биед нь нэгжлэг хийх, түүнчлэн байгуу-  
лагын захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

4. Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гу-  
таах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг эдрүү-  
лахыг хориглоно.

5. Нэр дэвшигчийг сонгуулийн үйл ажиллагаагаа явуулахад  
нь ажлын газар, байгууллагын захиргаа хууль тогтоомжид заас-  
ны дагуу ажлаас нь чөлөө олгож, дэмжлэг туслаацаа үзүүлнэ.

6. Монгол Улсын Ерөнхийлөгч нэр дэвшсэн тохиолдолд албан  
үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Харин Ерөнхийлөгчийн сон-  
гуультай холбогдсон асуудлаар аливаа байгууллага, албан ту-  
шаалтанд үүрэг даалгавар өгч, шийдвэр гаргуулж болохгүй.

28 дугаар зүйл. Сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа

1. Нэр дэвшигч өөрийн мөрийн хөтөлбөр, үзэл бодлоо чөлөөтэй тайлбарлан таниулах, нам болон сонгуульд хамтарсан  
кандидатууд нэр дэвшигчээ сурталчлах зорилгоор хурал, цуглаан хийх,  
уулзалт зохион байгуулах, ухуулах байр ажиллуулах болно.

2. Сонгуулийн сурталчилгааг санал хураах өдрөөс 24 цагийн  
өмнө зогсооно. Энэ үеэс өхлөн сонгууль явагдаж дуустал ямар  
кэг хэлбэрээр ухуулга, сурталчилгаа хийх, санал хураах өдөр  
хүртэл 7 хоногийн хугацаанд олон нийтийн санал асуулга явуу-  
лах, санал асуулгын дүн мэдээг нийтлэхийг хориглоно.

3. Улсын радио, телевиз, төрийн байгууллагын харьяалал  
бүхий сонин, сэтгүүлээр сонгуулийн ухуулга, сурталчилгаа үнэ  
төлбөргүй явуулах хугацаа, боломж нь нэр дэвшигч бүрт та-  
риуцан адил байна.

4. Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоож олгосон хугацаа-  
наас бусад цагт улсын радио, телевиз, төрийн байгууллагын  
харьяалал бүхий сонин, сэтгүүлээр нэр дэвшигчийн талаар сур-  
талчилгаа явуулбал үнэ төлбөрийг төлнө.

29 дүгээр зүйл. Нэр дэвшигчийн уулзалт

1. Нэр дэвшигч санал хураахаас 24 цагийн өмнө хүртэлх  
хугацаанд сонгогчидтой уулзалт хийж болно.

2. Нэр дэвшигчийг сонгогчидтой уулзахад нь тухайн шатны  
Засаг захиргаа, цутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга бүх  
түвшин дэмжлэг үзүүлнэ.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

*Санал хураах, анхан шатны сонгуулийн дүн гаргах*

*30 дугаар зүйл. Санал хураах газар, хугацаа*

1. Сонгогчдын саналыг санал хураахаар бэлтгэсэн байранд санал хураах өдөр 07 цагаас 22 цаг хүртэл хугацаанд хураана. Сонгогчдын санал хураах байр, хугацааг сонгуулийн хэсгийн хороо уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээнэ.

2. Сонгогчдоос саналаа нууцаар бэлтгэхэд хүрэлцэх тооны тасалгаа саналын хайрцаг бүхий байрыг тухайн сонгуулийн хэсгийг харьяалах сум, дүүргийн Засаг дарга хариуцаж бэлтгүүнэ.

*31 дүгээр зүйл. Саналын хуудас*

1. Саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан загварын дагуу хэвлэж, мөн хорооноос сонгуулийн нутаг дэвсгэрийн хороонд, нутаг дэвсгэрийн хорооноос салбар хороогоор дамжуулан санал хураах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороонд тус тус хүргүүнэ.

2. Саналын хуудсанд нэр дэвшигчийн овог, нэрийн ард нэр дэвшүүлсэн нам буюу сонгуульд хамтарсан намуудын нэрийг хэвлэлд бичиж хэвлэнэ. Нэр дэвшигчдийн нэрийг саналын хуудсанд хэвлэх дарваллыг Сонгуулийн ерөнхий хороо нутаг дэвсгэр, нийт сонгогчдын тоог харгалзан адил тэнцүү байх зарчмыг баримтлан солбиж байрлуулна.

3. Саналын хуудсанд тухайн сонгуулийн хэсгийн хорооны дарга, нэрийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна. Гарын үсэг, тэмдэггүй хуудсаар санал өгч болохгүй.

*32 дугаар зүйл. Санал хураах ажлыг зохион байгуулах*

1. Санал хураах өдрийн 07 цагт сонгуулийн хэсгийн хороонд бүрэлдэхүүн сонгогчдын төлөөлөгчдийг байлцуулан саналын бүх хайрцгийг шалган битүүмжилж, санал хураах ажиллагааг эхэлнэ. Энэ ажиллагаанд намын ажиглагчид, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчид байцаж болно.

2. Ажиглагч нь сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар хороонд бүртгүүлж үнэмлэх авсан байна. Ажиглагч сонгогчдын санал хураах, санал тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан гянах эрхтэй бөгөөд сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хутгалдан оролцож болохгүй.

Гадаадын ажиглагч сонгуулийн үйл ажиллагаанд оролцох журмыг Сонгуулийн ерөнхий хороо тогтооно.

3. Сонгуулийн хэсгийн хороо сонгогчийн иргэний паспорт, түүнтэй адилтгах баримт бичгийг нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрт саналын хуудас олгоно.

Санал хураах үед шинэжи ирэгчдийг тэдний иргэний паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг, шинэжүүлгийг нь үндэслэн нэрийн нэмэлт жагсаалтад бүртгэн, саналын хуудас олгоно.

4. Сонгогч саналаа өгснийг сонгогчдын нэрийн жагсаалт, иргэний паспортад тэмдэглэнэ.

### 33 дугаар зүйл. Сонгогч саналаа өгөх

1. Сонгогч санал хураах байранд ирж, саналаа өөрөө өгнө. Харин биений эрүүл мэндийн байдлаас болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас санал хураах байранд хүрэлцэн ирж чадахгүй сонгогчийн саналыг түүний хүсэлтээр сонгуулийн хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн очиж битүүмжилсэн хайрцагаар хураана.

2. Сонгогч саналын хуудсыг авч санал бэлтгэх тасалгаанд орж уг хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн овог нэрийг өмнөх дэс дугаарыг дугуйлан тэмдэглэж хуудсаа саналын хайрцагт хийнэ.

3. Сонгогч саналаа илэрхийлэхдээ алдаа гаргаж буруу тэмдэг тавьсан бол уг саналын хуудсаа саналын хайрцагт хийхөөс өмнө сонгуулийн хэсгийн хороонд энэ тухайгаа мэдэгдэж, хуудсаа хураалган дахин нэг саналын хуудас авч болно.

Хураалгасан саналын хуудсыг сонгуулийн хэсгийн хороо протоколд тэмдэглэж хадгална.

4. Санал бэлтгэх тасалгаанд тухайн сонгогчоос өөр хэн ч байж болохгүй. Саналын хуудсанд саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүний туслалцаа авч болно. Харин аль нэгэн намын сонгууль эрхэлсэн бэйгуулагын ажилтан, сонгуулийн хорооны гишүүн болон ажиглагчаар ийнхүү туслалцуулж болохгүй.

### 34 дүгээр зүйл. Саналын хуудсыг хүчингүйд тооцох

Дараахь тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно:

- 1) баталсан загварын бус хуудсаар санал өгсөн;
- 2) тухайн сонгуулийн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг, хэсгийн хорооны тэмдэггүй;



3) санаа огт тэмдэглээгүй, эсхүл нэгээс илүү хүний нэр тэмдэглэсэн, энэ хуульд зааснаас өөр ямар нэг тэмдэглэл хийсэн;

4) бүх нэр дэвшигчийн нэрийг дарсан;

5) нэр дэвшигчийн нэрийн өмнө тавьсан тэмдгийг засварласан.

*35 дугаар зүйл. Санаа тоолох*

1. Санаа тоолох ажлыг ил тод нээлттэй явуулна. Санаа тоолоход ажиглагчид, сонгогчдын болон хэвлэл, мэдээллийн төлөөлөгчид байлацаж болно.

2. 22 цаг болоогүй сонгуулийн хэсгийн хорооноос санаа тоолох тухай мэдэгдэж, олгоогүй үлдсэн саналын хуудсыг тоолж битүүмжилсний дараа саналын хайрцгийг нээж, санаа тоолох цаг болоогүй байхад саналын хайрцаг нээх, санаа тоолого завсарлахыг хориглоно.

3. Сонгуулийн хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг баримтлан тухайн хэсгийн нийт сонгогчийн тоо, саналын хуудас авсан сонгогчийн тоо, саналын хайрцагаас гарсан нийт буюу хүчинтэй болон хүчингүй хуудасны тоо, нэр дэвшигч бүрийн төлөө өгсөн саналын тоог сонгуулийн хэсгийн хэмжээгээр тоолж гаргана.

4. Сонгуулийн хэсгийн хороо хуралдаанаараа сонгогчдын санаа тоолсон дүнг хэлэлцэн шийдвэр гаргаж, уршин сонгосны дараа сонгуулийн нутаг дэвсгэрийн буюу түүний салбар хороонд ил даруй хүргүүлнэ.

*36 дугаар зүйл. Санаа хураалтын дүнг нэгтгэн хүргүүлэх*

1. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо нь өөрийн салбар хороо болон сонгуулийн хэсгийн хорооны шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн нийт сонгогчийн тоо, саналын хуудас авсан сонгогчийн тоо, хүчинтэй болон хүчингүй хуудасны тоо, нэр дэвшигч бүрийн төлөө өгсөн саналын тоог нэгтгэн гаргана.

2. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд явуулсан санаа хураалтын дүнг 3 хоногийн дотор гарган хуралдаанаараа хэлэлцэж, Сонгуулийн ерөнхий хороонд 2 хоногийн дотор мэдээлнэ.

*37 дугаар зүйл. Анхан шатны сонгуулийн дүн гаргах*

1. Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн нутаг дэвсгэрийн хороодын шийдвэрийг үндэслэн анхан шатны сонгуулийн нэгдсэн дүнг нэр дэвшигч бүрээр тооцож гаргана.

2. Сонгуулийн нэгдсэн дүнг гаргахдаа саналын хайрцагаас гарсан нийт саналын хуудсаар тооцно.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

*Санал хураалтын хүчингүй болсонд тооцох, дахин санал хураах*

*38 дугаар зүйл. Сонгуулийн хэсэгт санал хураалтыг хүчингүй болсонд тооцох, дахин санал хураах*

1. Сонгуулийн хэсэгт явуулсан санал хураалтыг сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо дараахь тохиолдолд хүчингүйд тооцно:

1) гал, усны аюул зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад нөхцөлд өмнө зарласнаас өөр байранд, түүнчлэн өмнө зарласнаас өөр өдөр санал хураасан;

2) санал хурааж эхэлснээс хойш сагаамн хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, хуульд заасан цагаас өмнө нээсэн (энэ нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасанд хамаарахгүй);

3) сонгуулийн хорооны гишүүн буюу сонгогчдод хүч хэрэглэн дарамт үзүүлсэн аливаа үйлдэл нь сонгогчийн санал, сонгуулийн дүнг гажуудуулахад хүргэсэн;

4) сонгуулийн хорооны гишүүд, бусад байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, хууран мэхлэх зэргээр сонгуулийн хуудлыг зөрчсөн нь сонгуулийн дүнд нөхтөй нөлөөлсөн.

2. Санал хураалтыг хүчингүй болсонд тооцсон тухай сонгуулийн нутаг дэвсгэрийн хорооны шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор дахин санал хураана. Дахин санал хураах шийдвэрийг сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо гаргана. Уг шийдвэрт дахин санал хураах байр, өдрийг заасан байвал зохино. Дахин санал хураалтыг ажлын өдөр явуулж болно. Санал хураалт сонгуулийн хэсгийн хэмжээгээр хүчингүй болсон тохиолдолд тухайн хэсгийн нийт сонгогчийг дахин санал хураалтад оролцуулна.

3. Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмаар санал хураах байранд өөрөө хүрэлцэн ирж чадахгүй сонгогчдын саналыг авсан саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, хуульд заасан цагаас өмнө нээсэн бол уг хайрцаг дахь сонгогчдын саналыг хүчингүйд тооцно. Энэ тохиолдолд уг хайрцагт санал өгсөн сонгогчдыг санал хураалтад дахин оролцуулна.

*39 дүгээр зүйл. Нэр дэвшигчийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол дахин санал хураалт явуулах*

1. Нэр дэвшигчдийн хэн нь ч сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд Сонгуулийн ерөнхий хороо дахин санал хураалтыг анхны санал хураалт явагдсанаас хойш 14 хоногийн дотор явуулна.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

*Сонгуулийн дүнг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах*

40 дүгээр зүйл. Санал хураалтыг хүчингүй болсонд тооцох, дахин санал хураалт, сонгууль явуулах тухай Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

1. Сонгуулийн ерөнхий хороо дараахь тохиолдолд санал хураалтыг хүчингүй болсонд тооцох тухай асуудлыг шийдвэрлүүлэхээр санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ:

1) сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн 50 хувь нь анхны санал хураалтад оролцоогүй;

2) хоёр дахь санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал аваагүй;

3) санал хураалт хуулийн дагуу явагдаагүй.

2. Улсын Их Хурал энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан үндэслэлээр санал хураалтыг хүчингүйд тооцсон бол нийнхүү шийдвэр гарснаас хойш дахин санал хураалтыг 60 хоногийн дотор зарлана. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан үндэслэлээр санал хураалтыг хүчингүйд тооцвол Улсын Их Хурал энэ тухай шийдвэр гаргаж 7 хоногийн дотор сонгууль дахин зарлана. Харин энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан үндэслэлээр санал хураалтыг хүчингүйд тооцсон бол Улсын Их Хурал уг асуудлыг нарийвчлан авч үзэж дахин санал хураалт, эсхүл сонгууль явуулах эсэхийг энэ хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ. Дахин санал хураалт, сонгууль явуулахад шаардлагатай бол сонгуулийн нутаг дэвсгэрийн болон түүний салбар, хэсгийн хороодыг шинэчлэн байгуулна. Түүнчлэн Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, сурталчилгаа явуулах зэрэг уг сонгуулийг бэлтгэн явуулах ажилд энэ хуулийн холбогдох заалтыг баримтална.

41 дүгээр зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль гаргах

1. Энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт зааснаар анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санаа авсан нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлэх тухай асуудлыг санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хорооны дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

2. Улсын Их Хурал анхан шатны сонгуулийн нэгдсэн дүнгийг тухай Сонгуулийн ерөнхий хорооны нэтгэлийг сонсож дараа нь энэ асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасан бол түүнийг сонсоно.

Илтгэл, дүгнэлтийг сонсооны дараа Улсын Их Хурлын гишүүд Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Цэцийн даргаас асууж таниацана.

3. Нэр дэвшигч болон анхан шатны сонгуулийн талаар Улсын Их Хурал дараахь асуудлаар нэг бүрчлэн санал хураана:

1) анхан шатны сонгуулийн санал хураалт хүчин төгөлдөр болсон;

2) нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоход харшлах шалтгаан байхгүй (харшлах шалтгаан гэдэгт нэр дэвшигч Үндсэн хуулийн гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй; гэмт хэрэг үйлдсэн нь анхан шатны сонгууль дууссанаас хойш шүүхээр тогтоогдсон болон сэтгэл мэдрэлийн хувьд эрүүд бус гэдэг нь амнэлгийн албан ёсны дүгнэлтээр батлагдсаныг ойлгоно).

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан асуудал бүрээр Улсын Их Хурлын гишүүдийн олонхи нь зөвшөөрсөн санал өгснөөр нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль батлагдана.

5. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн олонхи нь зөвшөөрсөн санал өгөөгүй бол энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлуудад нэгбүрчлэн тодруулж санал хураана. Санал хураалт бүрд Улсын Их Хурлын гишүүдийн олонхи нь зөвшөөрөөгүй (эсрэг) санал өгсөн бол энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны адил нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль батлагдана. Бусад тохиолдолд энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар эхицуулана.

6. Нэр дэвшигч нас нөгчсөн, түүнчлэн энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлүүдийн аль нэгийг хангаагүйн улмаас Ул-

сын Их Хурал нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргаагүй бо-гоод энэ зүйлийн бусад хэсэгт өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дахин зарлана.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

*Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон үед сонгууль зарлан явуулах, Ерөнхийлөгчийн сонгуулийн талаархи маргааныг шийдвэрлэх*

*42 дугаар зүйл.* Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон үед сонгууль зарлан явуулах

1. Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөө-лөгдсөн бол Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг 4 сарын дотор зарлан явуулна.

2. Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон үед Ерөнхийлөгчийн сонгууль зарлан явуулахад энэ хуулийн заалтыг баримтална.

*43 дугаар зүйл.* Ерөнхийлөгчийн сонгуулийн талаархи маргааныг шийдвэрлэх

Ерөнхийлөгчийн сонгуулийн талаархи маргааныг Үндсэн хуулийн цэц, шүүх, сонгуулийн хороо хууль тогтоомжид заасан харьяалаа, журмын дагуу шийдвэрлэнэ.

*44 дүгээр зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1993 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хуралын  
дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хуралын  
Тамгын газрын ерөнхий  
нэрийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 2 дугаар  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

«Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» 1992 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн Монгол Улсын хуулиар Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид заасан торгох ялын хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн Тусгай ангийн дараахь зүйл, хэсэгт заасан торгох ялын хэмжээг өөрчлөх, дөр дурдсанаар тогтоосугай:
  - 80 дугаар зүйлд: нэг зуун мянгаас дөрвөн зуун мянган төгрөг;
  - 98 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас тавин мянган төгрөг;
  - 99 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас хорин мянган төгрөг;
  - 106 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас тавин мянган төгрөг;
  - 107 дугаар зүйлд: хорин мянгаас наян мянган төгрөг;
  - 109 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас хорин мянган төгрөг;
  - 111 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;
  - 117 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас тавин мянган төгрөг;
  - 117 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;
  - 118 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянган төгрөг хүртэл;
  - 118 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: хорин мянгаас наян мянган төгрөг;
  - 123 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас хоёр зуун мянган төгрөг;

123 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: тавин мянгаас таван зуун мянган төгрөг;

124 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: гучин мянгаас хоёр зуун тавин мянган төгрөг;

126 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: дөчин мянгаас гурван зуун мянган төгрөг;

126 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: наян мянгаас таван зуун мянган төгрөг;

127 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас хоёр зуун мянган төгрөг;

127 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: тавин мянгаас таван зуун мянган төгрөг;

129 дүгээр зүйлд: хорин мянгаас нэг зуун мянган төгрөг;

130 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: нэг зуун мянгаас хоёр зуун тавин мянган төгрөг;

130 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: хоёр зуун тавин мянгаас таван зуун мянган төгрөг;

131 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: хорин мянгаас наян мянган төгрөг;

131 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: дөчин мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;

132 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин мянгаас нэг зуун мянган төгрөг;

133 дугаар зүйлд: тавин мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;

134 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: тавин мянгаас хоёр зуун тавин мянган төгрөг;

136 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван таван мянгаас наян мянган төгрөг;

137 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;

138 дугаар зүйлд: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;

143 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин мянгаас дөчин мянган төгрөг;

143 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: гучин мянгаас жаран мянган төгрөг;

144 дүгээр зүйлд: арван мянгаас тавин мянган төгрөг;

146 дугаар зүйлд: арван мянгаас жаран мянган төгрөг;

148 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: тавин мянгаас нэг зуун мянган төгрөг;

- 149 дүгээр зүйлэд: хорин мянгаас найн мянган төгрөг;  
150 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тавин мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;  
150 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: жаран мянгаас хоёр зуун тавин мянган төгрөг;  
151 дүгээр зүйлэд: арван мянгаас хорин таван мянган төгрөг;  
152 дугаар зүйлэд: хорин таван мянгаас тавин мянган төгрөг;  
163 дугаар зүйлэд: тавин мянгаас хоёр зуун тавин мянган төгрөг;  
164 дүгээр зүйлэд: хорин таван мянгаас тавин мянган төгрөг;  
165 дугаар зүйлэд: жаран мянгаас хоёр зуун тавин мянган төгрөг;  
166 дугаар зүйлэд: арван мянгаас хорин таван мянган төгрөг;  
168 дугаар зүйлэд: тавин мянгаас хоёр зуун тавин мянган төгрөг;  
169 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;  
170 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: жаран мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;  
171 дүгээр зүйлэд: тавин мянгаас хоёр зуун тавин мянган төгрөг;  
172 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин мянгаас найн мянган төгрөг;  
172 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: тавин мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;  
173 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас жаран мянган төгрөг;  
173 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: дөчин мянгаас нэг зуун мянган төгрөг;  
174 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: гучин мянгаас жаран мянган төгрөг;  
174 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: тавин мянгаас нэг зуун мянган төгрөг;  
176 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас найн мянган төгрөг;  
177 дугаар зүйлэд: арван мянгаас дөчин мянган төгрөг;  
178 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас гучин мянган төгрөг;  
178 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: хорин таван мянгаас тавин мянган төгрөг;  
181 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: тавин мянгаас нэг зуун мянган төгрөг;



182 дугаар зүйлэд: арван мянгаас тавин мянган төгрөг;

183 дугаар зүйлэд: хорин таван мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;

184 дугаар зүйлэд: арван мянгаас тавин мянган төгрөг;

185 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;

187 дугаар зүйлэд: хорин таван мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;

188 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: тавин мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;

189 дугаар зүйлэд: хорин таван мянгаас тавин мянган төгрөг;

190 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас тавин мянган төгрөг;

191 дугаар зүйлэд: арван мянгаас наян мянган төгрөг;

194 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;

206 дугаар зүйлэд: хорин таван мянгаас тавин мянган төгрөг;

209 дугаар зүйлэд: арван мянгаас тавин мянган төгрөг;

210 дугаар зүйлэд: арван мянгаас тавин мянган төгрөг;

216 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас хорин таван мянган төгрөг;

216 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: арван мянгаас дөчин мянган төгрөг;

217 дугаар зүйлэд: хорин таван мянгаас наян мянган төгрөг;

218 дугаар зүйлэд: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;

219 дугаар зүйлэд: хорин мянгаас гучин мянган төгрөг;

220 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;

221 дугаар зүйлэд: хорин таван мянгаас тавин мянган төгрөг;

224 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: арван таван мянгаас далаан таван мянган төгрөг;

225 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин мянгаас нэг зуун мянган төгрөг;

225 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: хорин мянгаас жаран мянган төгрөг;

226 дугаар зүйлэд: арван мянгаас тавин мянган төгрөг;

228 дугаар зүйлэд: арван таван мянга хүртэл төгрөг;

229 дугаар зүйлэд: арван мянгаас дөчин мянган төгрөг;

230 дугаар зүйлэд: дөчин мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;

- 232 дугаар зүйлд: арван мянгаас гучин мянган төгрөг;  
233 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас далан таван мянган төгрөг;  
234 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: тавин мянгаас хоёр зуун мянган төгрөг;  
235 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван таван мянгаас дөчин мянган төгрөг;  
236 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас тавин мянган төгрөг;  
237 дугаар зүйлд: гучин мянган төгрөг;  
238 дугаар зүйлд: тавин мянгаас нэг зуун мянган төгрөг;  
239 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: хорин мянгаас жаран мянган төгрөг;  
240 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: хорин мянгаас жаран мянган төгрөг;  
244 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;  
246 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;  
247 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: гучин мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;  
247 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: арван мянгаас тавин мянган төгрөг;  
248 дугаар зүйлд: арван мянгаас дөчин мянган төгрөг;  
249 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас тавин мянган төгрөг;  
251 дүгээр зүйлд: хорин мянгаас тавин мянган төгрөг;  
252 дугаар зүйлд: хорин мянгаас нэг зуун мянган төгрөг;  
253 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: тавин мянгаас нэг зуун тавин мянган төгрөг;  
253 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;  
256 дугаар зүйлд: хорин мянгаас нэг зуун мянган төгрөг;  
258 дугаар зүйлд: тавин мянгаас нэг зуун мянган төгрөг;  
260 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас далан таван мянган төгрөг;  
261 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: хорин таван мянгаас далан таван мянган төгрөг;  
261 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: хорин таван мянгаас далан таван мянган төгрөг;

262 дугаар зүйлд: арван таван мянгаас нэг зуун мянган төгрөг;

263 дугаар зүйлд: хорин мянгаас нэг зуун мянган төгрөг;

265 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: хорин таван мянгаас нэг зуун мянган төгрөг;

267 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: хорин мянгаас далаан таван мянган төгрөг.

2. Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «олон нийтийн өмнө буруушаах» гэсний дараа «торгох» гэж нэмж, мөн хэсгийн «...торгох ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай» гэснээс «торгох» гэснийг зассугай.

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 169 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох ялыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ хуулийг 1993 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

5. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын  
дэргэ

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын  
Тамгын газрын ерөнхий  
сарийн бичгийн дэргэ

Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ**

1993 оны 3 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦААГ  
ХОЙШЛУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуульд тавьсан хоригийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан «Зарим хууль, хуулийн заалт, зарлигийг хүчингүй болсонд тооцох тухай» 1993 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн Монгол Улсын хуулийг Монгол Улсын Прокурорын тухай хууль хүчин төгөлдөр болтол мөрдөхгүй байхад тогтоосугай.

Монгол Улсын Их Хурлын  
дэд дарга

**Ж. ГОМБОЖАВ**

Монгол Улсын Их Хурлын  
Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

**Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫН  
ТОГТООЛ

1993 оны 1 дүгээр

Дугаар 12

Улаанбаатар

сарын 21-ний өдөр

хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын холбогдох шийдвэрийг Монгол Улсын Онцгой албан татварын хуульд нийцүүлэх арга хэмжээг 1993 оны 2 дугаар сарын 1-ний дотор авахыг Засгийн газарт даалгасугай.

Дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

Тамгын газрын өрөмхий  
парийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 1 дүгээр

Дугаар 13

Улаанбаатар

сарны 26-ны өдөр

хот

АЙЛЧААЛЫН ДҮНГИЙН ТУХАЙ

Монгол улсын Ерөнхийлөгч П. Очирбат Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Б. Н. Ельциний урилгаар Оросын Холбооны Улсад албан ёсны айлчлал хийсэн тухай мэдээллийг сонсоод Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Оросын Холбооны Улсад Монгол улсын Ерөнхийлөгч П. Очирбатын хийсэн албан ёсны айлчлалын дүнг сайшаасугай.
2. Уг айлчлалын үеэр хэлэлцэн тохирсон асуудлыг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороод, Засгийн Газарт үүрэг болгосугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 1 дүгээр

Дугаар 14

Улаанбаатар

сарын 28-ны өдөр

хот

ХУУЛИЙН ТӨСӨЛ БУЦААХ ТУХАЙ

«Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль»-ийн төслийн анхны хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын санааны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь дэд хэсгийн «в»-г үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. «Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль»-ийн төслийг дахин боловсруулахаар хууль санаачлагчид буцаасугай.

2. Уг зуулийн төслийг дахин боловсруулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

- |                |   |
|----------------|---|
| 1) Д. Дашцэдэн | — Улсын Их Хурлын Хурал, захиргааны байнгын хорооны дарга |
|----------------|---|

Гишүүд:

- |                    |  |
|--------------------|--|
| 2) Д. Батбаатар    | — Улсын Их Хурлын гишүүн                   |
| 3) С. Батмөнх      | — " —                                      |
| 4) Ч. Зоригтбаатар | — " —                                      |
| 5) Ц. Элбэгдорж    | — " —                                      |
| 6) О. Шаалуу       | — " —                                      |
| 7) М. Энхсайхан    | — " —                                      |
| 8) Б. Энэбиш       | — Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөгч    |
| 9) Д. Ганзориг     | — Хурал, захиргааны байнгын хорооны туслах |
| 10) Н. Дашдорж     | — Ерөнхийлөгчийн Тамгын газрын түшмэл      |

3. Хэвлэлдүүлгийн явцад Улсын Их Хурлын байнгын хороо гишүүдийн гаргасан санал, дүгнэлтийг харгалзан төслийг дахин боловсруулж 1993 оны 2 дугаар сарын 6-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг ажлын хэргийн ахлагч (Д. Дашцэдэн)-д даалгасугай.

Дарга

Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

Н. БАГАБАНДИ

Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1993 оны 2 дугаар

Дугаар 15

Улаанбаатар

сарын 4-ний өдөр

хот

## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн дагуу шүүхүүдийг байгуултал Улсын дээд шүүх, аймаг, хот, хэсэг, районы болон тусгай шүүхүүд бүрэн эрхээ хэрэгжүүлж байхаар тогтоосугай.

2. Тухайн шүүгчийг чөлөөлөх талаар Ерөнхийлөгчийн шийдвэр гараагүй бол Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн дагуу шүүгчдийг томилогдтол бүх шатны шүүхэд ажиллаж байгаа шүүгчид шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж байсугай.

3. Энэ хуулийн байцаан шийтгэх ажиллагаатай холбогдсон зүйл, заалтыг тухайн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн баталж хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөхгүй байхаар тогтоосугай.



4. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх батаагааны заалтуудыг буцааж хэрэглэхгүй байхаар тогтоосугай.

5. Шүүхийн ерөнхий зөвлөлд сонгогдох шүүгчдийг бүх шатны шүүхийн одоогийн бүрэлдэхүүнээс нэр дэвшүүлэн Улсын дээд шүүхийн хураалдаанаас сонгохыг зөвшөөрсүгэй.

6. Шүүхийн ерөнхий зөвлөлд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхлэх хүртэл Улсын дээд шүүх, Хууль зүйн яам, тэдгээрийн харьяа байгууллагууд шүүхийн зохион байгуулалтын удирдлага, тогтоол гүйцэтгэлийн талаарх бүрэн эрхээ үргэлжлүүлэн хэрэгжүүлж байсугай.

7. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлд бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш нэг сарын дугацаанд багтаан Хууль зүйн яамны шүүхийн зохион байгуулалтын удирдах газар, тогтоол гүйцэтгэлийн албыг төв, орон нутагт ажиллаж буй холбогдох ажилтны орон тоо, төсөв, хөрөнгийн хамт шилжүүлэн хүлээлцэхийг Монгол Улсын Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгасугай.

8. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн дагуу шүүхүүдийг байгуулах тухай саналаа 1993 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн барихыг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгасугай.

9. Монгол Улсын Шүүхийн тухай хууль батлагдаж хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан энэ тогтоолын хавсралтад заасан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, БНМАУ-ын Бага Хурлын тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Дарга

Тамгын газрын ерөнхий  
нэрийн бичгийн дарга

Н. БАГАБАНДИ

Н. РИНЧИНДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1993 оны  
15 дугаар тогтоолын хавсралт

ХҮЧИНГҮҮЙ БОЛСОНД ТООЦСОН БНМАУ-ЫН АРДЫН  
ИХ ХУРАЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ, БНМАУ-ЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

1. «БНМАУ-ын шүүхийн байгууллагуудын зохион байгуулаатад зарим өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1961 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 262 дугаар зарлиг.

2. «БНМАУ-ын шүүгч нарын сахилга батын хариуцаагын тухай дүрмийг батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 3 дугаар зарлиг.

3. «Цэргийн коллегийг байгуулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 13 дугаар зарлиг.

4. «Шүүхэд үүргээ гүйцэтгэсэн ардын төлөөлөгчдөд цалин зөвс, зардал олгох журмын тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 301 дүгээр зарлиг.

5. «БНМАУ-ын Ардын шүүхийг сонгох сонгуулийн тухай дүрмийг батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1984 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 100 дугаар зарлиг.

6. «Хэсгийн ардын шүүх, хэсгийн прокурорын байршлын тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 80 дугаар зарлигийн шүүхтэй холбогдсон заалт.

7. «Шүүхийн зохион байгуулалтын удирдлагын тухай» БНМАУ-ын Бага Хурлын 1990 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 23 дугаар тогтоол.

8. «БНМАУ-ын шүүгчийн тангараг батлах тухай» БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 13 дугаар тогтоол.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫН  
ТОГТООЛ

1993 оны 2 дугаар

Дугаар 17

Улаанбаатар

сарын 8-ны өдөр

хот

МОНГОЛ УЛСЫН НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Дараахь арга хэмжээг 1993 оны 4 дүгээр сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай;

1) Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэрийг нийцүүлэх;

2) Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, нягтлан бодох бүртгэлийн маягт, аргачлалыг хуульд заасан журмын дагуу боловсруулан гаргах.

Дарга

Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

Н. БАГАБАНДИ

Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 2 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

БҮГД НАЙРАМДАХ БОСНА-ГЕРЦЕГОВИНА  
УЛСТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ  
ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Босна-Герцеговина Улстай дипломат харилцаа тогтоосугай.

Дарга

Тамгын газрын ерөнхий  
нарийн бичгийн дарга

Н. БАГАБАНДИ

Н. РИМЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 2 дугаар

сарын 11-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар

ЭӨТ

БҮГД НАЙРАМДАХ СЛОВЕНИ УЛСТАЙ  
ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Словени Улстай дипломат харилцаа тогтоосугай.

Дарга

Тамгын газрын ерөнхий  
нэрийн бичгийн дарга

Н. БАГАБАНДИ

Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 2 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар  
хот

БҮГД НАЙРАМДАХ ХОРВАТ УЛСТАЙ  
ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Хорват Улстай дипломат харилцаа тогтоосугай.

Дарга

Тамгын газрын ерөнхий  
сарийн бичгийн дарга

Н. БАГАБАНДИ

Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 2 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТИЙН  
ТУХАЙ

Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим зүйл, заалт нь Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 2 дугаар сарын

12-нм өдрийн 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Үндсэн хуулийн цэцгийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

Тамгын газрын ерөнхий  
шэргийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1993 оны 2 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар  
хот

### ЗАРИМ БАРААГ ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАГ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Дор дурдсан барааг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй:

- 1) Багахангайд баригдаж байгаа мах боловсруулах үйлдвэрт зориулсан Финланд Улсын хүүгүй зээлээр санхүүжингдэх тоног төхөөрөмж;
- 2) 1993 онд импортлоор авах гурвал, будаа, шахмал ногоон цай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Тамгын газрын ерөнхий  
шэргийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 2 дугаар

сарын 16-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар

хот

Р. ЖАМЪЯНЧОЙЖИЛЫГ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын Тамгын газрын хууль тогтоомжийн шин-  
жилгээ-дэвдэмжийн хэлтсийн хэсгийн ахлагч Рэгзэнгийн  
Жамъянчойжилыг Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн  
 гишүүнээр томиласугай.

Дарга

Тамгын газрын ерөнхий  
нэрийн бичгийн дарга

Н. БАГАБАНДИ

Н. РИНЧИНДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 2 дугаар

Дугаар 25

Улаанбаатар

сарын 18-ны өдөр

ХОТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
СОНГУУЛЬ ТОВАЛОН ЗАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 9 дүгээр зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санаал хураалтыг 1993 оны 6 дугаар сарын 6-ны өдөр явуулахаар тогтоосугай.
2. Энэ тогтоолыг 1993 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

Тамгын газрын ерөнхий  
илрийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 3 дугаар

Дугаар 26

Улаанбаатар

сарны 29-ний өдөр

ХОТ

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН  
ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох 1993 оны сонгуульд улсын төсвөөс зарцуулах зардлын хэмжээг 40.0 сая төгрөгөөр баталсугай.
2. Улсын төсвөөс зарцуулах сонгуулийн зардлыг санхүүжүүлэхийг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

Тамгын газрын ерөнхий  
сарийн бичгийн дарга

Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 4 дугаар

Дугаар 27

Улаанбаатар

сарын 5-ны өдөр

хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ГУЧДУГААР ЗҮЙЛИЙН 2 ДАХЬ ХЭСГИЙН  
ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох хүнд тавигдах шаардлагын тухай Үндсэн хуулийн гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн зарим заалтыг дараахь байдлаар ойлгон хэрэглэж байхаар тогтоосугай:

1. «...сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан...» гэдгийг Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураах өдрөөс өмнөх хуанлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар гадаад улсад оршин суугаагүй гэж ойлгоно.

2. «...Монгол Улсын уугуул иргэн...» гэж Монгол Улсын харьяат эцэг, эхээс төрж, түүнээс хойш Монгол Улсын харьяат хэвээр байгаа хүнийг ойлгоно.

Дэд дарга

Тамгын газрын ерөнхий  
ярийн бичгийн дарга

Ж. ГОМЕОЖАВ

Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1993 оны 4 дүгээр

Дугаар 28

Улаанбаатар

сарын 5-ны өдөр

хот

### ШАЛГАЛТ ХИЛХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Засгийн газраас гаргасан шийдвэр Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид хэрхэн нийцэж байгааг шалгаж дүнг 1993 оны 4 дүгээр сарын 20-ны дотор Улсын Их Хурлын чуулганд танилцуулахыг Хууль зүйн байнгын хороонд даалгасугай.

2. Өмч хувьчлалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас аян явуулж байгаа арга хэмжээтэй шалган танилцаж дүнг 1993 оны 5 дугаар сарын 20-ны дотор Улсын Их Хурлын чуулганд танилцуулахыг Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороонд даалгасугай.

3. Яам, төрийн захиргааны бусад төв байгууллагын боловсрол, нийслэлийн засаг даргын шийдвэр Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн нийцэж байгаагаар 1993 оны 5 дугаар сарын 1-ний дотор танилцаж дүнг олон нийтэд мэдээлэхийг Засгийн газарт үүрэг болгосугай.

Дэд дарга

**Ж. ГОМЕОЖАВ**

Төлмөн газрын ерөнхий  
сарийн бичгийн дарга

**Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 1 дүгээр

Дугаар 12

Улаанбаатар

сарын 26-ны өдөр

ХТ

Ч. ЦЭРЭНДАГВАД ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монголын ардын цэргийн дугаар нэгтгэлийн захирагч хуран-  
даа Чулуун овогтой Цэрэндагвал хошууч генерал цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 1 дүгээр

Дугаар 13

Улаанбаатар

сарын 26-ны өдөр

ХТ

ЗАРИМ ХҮНИЙГ СҮХБААТАРЫН  
ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Монгол ардын үндэсний хувьсгал, ардын төрийг үүсгэн зохион байгуулсан улс төрийн гарамгай зүтгэлтнүүдийн нэг, Монголын ардын цэргийг үндэслэн байгуулагч Дамдин Сүхбаатарын мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан ардын хувьсгалын партизан дарагч хүмүүсийг СҮХБААТАРЫН одонгоор шагнасугай.

1. Дамчаагийн ЦОЛМОН
2. Пэлжээгийн НЯМХҮҮ
3. Бадмын ГОМБОЖАВ
4. Чойжилын ЛОДОН

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1993 оны 1 дүгээр

Дугаар 14

Улаанбаатар

сарын 26-ны өдөр

ХОТ

**3. ГАЛСАНДАНЗАНГ ХӨДӨЛМӨРИЙН  
ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР  
ШАГНАХ ТУХАЙ**

Монгол ардын үндэсний хувьсгал, ардын төрийг үүсгэн зохион байгуулсан улс төрийн гарамгай зүтгэлтнүүдийн нэг, Монголын ардын цэргийг үндэслэн байгуулагч Дамдины Сүхбаатарын дүрийг урлагийн тайз дэлгэцнээ амжилттай бүтээснийг үнэлж Хүүхэд залуучуудын театрын жүжигчин Зундуй овогтой **ГАЛСАНДАНЗАНГ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН** одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1991 оны 1 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

КАЗУО ТАКОМОТОГ НАЙРАМДАЛ  
МЕДАЛЬ-ААР ШАГНАХ ТУХАЙ

Монгол-Японы хамтарсан үйлдвэр байгуулж түүний үр өгөөжийг дэвшүүлэхэд идэвх зүтгэл гарган ажиллаж байгааг үнэлж Монгол-Японы хамтарсан «Тэхь» компанийн ерөнхий захирал КАЗУО ТАКОМОТОГ НАЙРАМДАЛ МЕДАЛЬ-аар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 1 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

Э. БЯМБАЖАВЫГ ХАВСРАН СУУХ  
ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Эрдэнийн Бямбажавыг Мон

гол Улсаас Бүгд Найрамдах Кыргызстан Улсыг хавсран суух  
Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 2 дугаар

Дугаар 19

Улаанбаатар

сарын 4-ний өдөр

ХОТ

Б. ШАРЫГ ШУДАРГА ЖУРАМ МЕДАЛНАР  
НЭХЭН ШАГНАХ ТУХАЙ

Байгалийн гэнэтийн аюулаас нийгмийн болон амны олон  
малыг толгой бүрэн хамгаалахын төлөө амь бие хайргүй тэмц-  
сэнийг үнэлж Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Рашаан-  
тын IV багийн иргэн Бужгарын Шарыг ШУДАРГА ЖУРАМ  
медалнар нэхэн шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1993 оны 2 дугаар  
сарны 6-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН СОЁРХОЛ ХҮРТЭЭХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ТУХАЙ**

1. Монгол Улсын Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн даргаар Улсын Их Хурлын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хорооны дарга, биологийн ухааны доктор **Ж. Батсуурийг** баталсугай.

2. Өөр ажилд шилжсэн тул Төрийн соёрхол хүртээх зөвлөлийн даргын үүрэгт ажлаас **К. Зардыханыг**, гишүүний үүрэгт ажлаас **Ж. Батсуурийг** тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1993 оны 2 дугаар  
сарны 27-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар  
хот

**И. ОЧИРБАЛЫГ ЭЛЧИН САЙДЫН ҮҮРЭГТ  
АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Ишцогийн Очирбалыг Монгол Улсаас Данийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 2 дугаар

Дугаар 43

Улаанбаатар

сарын 27-ны өдөр

ХОТ

А. МУНДАГБААТАРЫГ ЭЛЧИН САЙДЫН  
ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Лувсандоржийн Мундагбаатарыг Монгол Улсаас Люксембургийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 2 дугаар

Дугаар 44

Улаанбаатар

сарын 27-ны өдөр

ХОТ

Ж. ГАНИБАЛЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ  
ТУХАЙ

Жагваралын Ганибалыг Монгол Улсаас Данийн Вант Улсад халсран суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 2 дугаар

Дугаар 45

Улаанбаатар

сарын 27-ний өдөр

ХӨТ

Ж. ГАНИБАЛЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ  
ТУХАЙ

Ялагваралын Ганибалыг Монгол Улсаас Люксембургийн Вант Улсад хавсран суух Онд богээд Бүрэн эрхт элчин сайдаар томиласугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 3 дугаар

Дугаар 31

Улаанбаатар

сарын 24-ний өдөр

ХӨТ

Б. ЦЭРЭНДОРЖИЙГ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Б. Цэрэндоржийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томиласугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 3 дугаар

Дугаар 52

Улаанбаатар

сарын 27-ны өдөр

ХОТ

ДЭЛХИЙН МОНГОЛЧУУДЫН «ИХ ЧУУЛГАН»  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

1. Дэлхийн монголчуудын хэлхээ холбоог хөгжүүлэх, тэдэнтэй эдийн засаг, соёл, мэдээллийн талаар хамтран ажиллах таатай боломжийг бүрдүүлэх, үндэсний хэл, соёлоо өвлөн улмаар хүмүүнлэг харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дэлхийн монголчуудын Их чуулганыг зохион байгуулах талаар Монголын Хөгжлийг дэмжих сан-нийгэмлэг, Монголын энх тайван найрамдлын байгууллагуудын Холбооноос дэвшүүлсэн саналыг ёсоор болгох нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Дэлхийн Монголчуудын «Их чуулган»-ыг 1993 оны 9 дүгээр сарын 13—20-нд Улаанбаатар хотноо чуулуулж хөрөнгийг улсын төсвөөс гарган, чуулганыг зохион байгуулахад туслах талаар шаардагдах арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1993 оны 4 дүгээр

Дугаар 53

Улаанбаатар

сарын 1-ний өдөр

хот

**ЗАРИМ ХҮНИЙГ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Монгол Улсад мэргэжилтэй ажилчин бэлтгэх, мэргэжлийн дадлага чадварыг дээшлүүлэх талаар идэвх сансачилга гарган үр бүтээлтэй ажиллаж байгааг үнэлж Бүгд Найрамдах Кыргызстан улсын Техник мэргэжлийн улсын хорооны дарга Касендеевич Ильяс Касендеевийг ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ медалиар, Техник мэргэжлийн 17 дугаар сургуулийн багш Бейшекеевна Айнагуль Бейшекееваг НАИРАМДАЛ медалиар тус тус шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1993 оны 4 дүгээр

Дугаар 54

Улаанбаатар

сарын 2-ны өдөр

хот

**ЛҮДЭВДОРЖИЙН ХАШБАТЫГ ЭЛЧИН САЙДЫН  
ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Лүдэвдоржийн Хашбатыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИВЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1993 оны 4 дүгээр

Дугаар 55

Улаанбаатар

сарны 2-ны өдөр

хот

**ХАСБАЗАРЫН БЭХБАТЫГ ЭЛЧИН САЙДААР  
ТОМИЛОХ ТУХАЙ**

Хасбазарын Бэхбатыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали  
Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИВЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1993 оны 4 дүгээр

Дугаар 56

Улаанбаатар

сарны 7-ны өдөр

хот

**Г. ДАШТҮДЭВИЙГ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ  
ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГААР  
ТОМИЛОХ ТУХАЙ**

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн  
даргаар Гонгор овогтой Даштүдэвийг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН  
ХУУЛИЙН ЦЭЦИЙН  
ТОГТООЛ

1993 оны 1 дүгээр

Дугаар 01

Улаанбаатар

сарын 13-ны өдөр

хот

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хуралдааныг Цэцийн дарга Г. Сонд даргаалж, гишүүдэд Г. Нямдоо, А. Баасан, Ц. Цолмон, Н. Жанцан, Ж. Чойжанцан, Ж. Бямбаа, Б. Дангасүрэн, Д. Чинхаажав нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б. Цэндээхүүг оролцуулан хийсэн хуралдаанаар «Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай» Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоол Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн тухай маргааныг дахин хэлэлцэв.

Хуралдаанд маргагч талуудыг төлөөлж Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадорж, Сэлэнгэ аймгийн «Бугант» компанийн ерөнхий захирал И. Бадарч, гэрчээр Засаг захиргааны яамны ажилтан Б. Шарбанди нар оролцов.

Иргэн И. Бадарч Үндсэн хуулийн Цэцэд хэлэглэн «Ардын өрх» сонинд ирүүлсэн мэдээлэлдээ: «Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулсан Улсын Их Хурлын 1992 оны 24 дугаар тогтоол нь тэдгээрийн өдгийн зэсгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан үзээгүй, үндэслэл муутай шийдвэр болсон төдийгүй, ноцтой нь орон нутгийн тухайн хурал, иргэдийн саналыг авлаагүй тул Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг бүдүүлгээр зөрчлөө. Энэ асуудлыг зохих журмаар шалган үзэж, хариу өгөхийг хүсье» гэжээ.

Энэхүү мэдээллийг үндэслэн Цэцийн гишүүн Н. Жанцан маргаан шийдвэрлэх ажиллагааг үүсгэн холбогдох шалгалтыг хийгээд уг маргааныг Цэцийн хуралдаанаар хянан хэлэлцээд 1992 оны 12 дугаар сарын 2-нд гаргасан 01 тоот дүгивэлтэд: «Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь

нэгтгэн харьяалуулах тухай» Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоолыг боловсруулах, батлах явцдаа Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3-т заасан «засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ» гэсэн заалтын шаардлагыг хангаагүй байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхдөө нэгэнт Үндсэн хуульд заасан урьдчилан судалж харгалзан үзэх, үндэслэл болгох шаардлагыг хангаагүй тул Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж үзлээ» гэжээ.

Энэ дүгнэлтийг хянан хэлэцгээд Улсын Их Хурлаас гаргасан 1992 оны 12 дугаар сарын 22-ны 41 дүгээр тогтоолд: «Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн гаргасан Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолын заалт нь Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалттай холбогдоагүй гэж үзээд уг тогтоолыг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй» гэжээ.

Үндсэн хуулийн Цэцгийн хуралдааны хэлэлцүүлэгт оролцсон иргэн И. Бадарч мэдүүлэхдээ: «Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчиж гарсан Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолыг хүчинтэй хэвээр үлдээж Цэцгийн хууль ёсны дүгнэлтийг хүлээж аваагүй явдал сэтгэл дундуур байна. Үндсэн хуулийн Хавсралтын хууль нь Үндсэн хуулийг засварлан хэрэглэх хууль биш баймаар юм. Тухайн хурал, иргэдийн санал авахгүйгээр Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөнийг Хавсралт хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг баримтлан шийдвэрлэсэн гэдгээр няцаах үндэсгүй юм. Үүн хэрэг дээрээ Хавсралт хуулийг Үндсэн хуулаас дэргүүр тавьсан ажиллагаа гэж үзэхээс өөр аргагүй байна. Миний ойлгосноор Хавсралт хууль нь тодорхой үе шатанд хэрэгжээд шууд хүчингүй болох ёстой хууль юм. Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан «өөрчлөх» гэдэгт «нэгтгэн харьяалуулах» гэсэн ойлголт багтах учраас Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн нь маргаангүй. Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолын заалтууд одоо хүртэл биелэгдэхгүй байгааг анхааралдаа авах нь зүйтэй байна» гэв.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадорж мэдүүлэхдээ: «Цэцгийн энэхүү хуралдаан нь маргааныг зүслэн шийдвэрлэх их хариуцлагатай юм.



Урьдах хуралдаанд оролцож тайлбараа тодорхой ирсэн учраас даргаар асуудлыг тайлбарын чанартайгаар хэлж, Улсын Их Хурлын 1992 оны 41 дүгээр тогтоол нь зөвхөн Хавсралт хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэсэн бөгөөд Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хамаарч байгаа юм. Ийм ч учраас 24 дүгээр тогтоол Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтад хамаарагдахгүй юм. Энэ тогтоол нь «хот, тосгоны эрх зүйн байдалын тухай хууль» гарах хүртэл ич хэрэгшүүдсэн түр арга хэмжээ гэж ойлгож байгаа.

Гэрч Засаг захиргааны ламны ажигтан Б. Шарбанди мэдүүлэхдээ: «Энэ асуудлыг анхнаас нь боловсруулах ажигчид би оролцсон, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу орон нутгийн хот, хороод бүгд 20 нэгжийн 7-г нь бие даасан сум болгох, 13-ыг нь тухайн суманд нь нэгтгэх саналыг Улсын Их Хуралд оруулсан юм. Нэгж оруулахдаа аймгуудын саналыг авсан бөгөөд, тухайн хурал, иргэдийн саналыг тухайлан аваагүй» гэв. Энэ асуудлын талаарх хавтаст материалаас холбогдох нотлох баримтыг нэг бүрчлэн судлан үзэж, маргаалдагч талууд мэтгэлцэж бие биедээ асуулт тавьж, харилат авах замаар хэлэлцүүлэг явагдан.

Хянавал:

1. «Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолын заалт нь Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалттай холбогдоогүй» гэсэн 41 дүгээр тогтоолын заалт 24 дүгээр тогтоолтой шууд зөрчилдөж байна. Учир нь 24 дүгээр тогтоолыг Улсын Их Хурал гаргахдаа Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийг бүхэлд нь үндэслэжээ. Орон нутгийн харьяалаалтай хот, хороодыг зохих суманд нь нэгтгэн харьяалуулах асуудлыг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн бүх заалтын дагуу хийх ёстой. Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийг үндэслэнэ гэдэг нь түүний доторхи хэсгүүд, тухайлбал 3 дахь хэсгийг үндэс болгожээ гэдэг нь ойлгомжтой юм. Ийм учраас «Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолын заалт нь Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалттай холбогдоогүй» гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

2. Цэцгийн дүгивэтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхэд хурал, захиргааны байнгын хороо болон Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадорж нараас оруулж хэлэлцүүдсэн дүгнэлт, зарим гишүүдийн хэлсэн үг, саналд: «орон нутгийн харьяалаалтай хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулсан нь «хот, тосгоны эрх зүйн байдалын тухай хууль» гаргах хүртэл авсан түр зуурын чанартай арга хэмжээ бөгөөд Улсын Их Хурал

Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэ асуудлыг 1992 онд багтаан шийдвэрлэнэ» гэсэн заалтыг биелүүссэн учир Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзжээ. Үндсэн хуулийн Хавсралт хууль нь Үндсэн хуультай адил хүчин чадалтай боловч Үндсэн хууль биш ээ. Үүнийг «БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай» Үндсэн хуулийн Хавсралт хууль гэсэн нэр нь баталж байна. Иймд Хавсралт хууль нь хуучин Үндсэн хуулиас шинэ Үндсэн хуулийг дагаж мөрдөх шилжилтийн үед Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцыг тодорхойлсон хууль мөн. Хавсралт хууль шилжилтийн үед хэрэгжээд төрийн шинэ тогтолцоо бүрнээ бүрдсэн үед түүхэн үүргээ гүйцэтгээнд тооцогдоно. Учир иймээс Хавсралт хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу уг асуудлыг хийж гүйцэтгэхээр заасан тул Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зайлшгүй баримтлах хуулийн шаардлага гарч ирж байгаа юм.

Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт «...зарим аймгийн нутаг дэвсгэрт байгаа орон нутгийн харьяалаалтай хот, өөр сумын нутаг дэвсгэрт байгаа хороог зохих аймаг, суманд нэгтгэн харьяалуулах» гэдэг нь зааваа тухайн суманд нь ямар ч тохиолдолд шууд нэгтгэх гэсэн ойлголт биш байна.

Үндсэн хуулийн Хавсралт хуулийн зүйл бүрт «Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу» гэж хуульчилснаас үзэхэд Хавсралт хууль нь Үндсэн хуулийн заалт, шаардлагын дагуу хэрэгжих ёстой нь тодорхой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцгийн хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадоржоос гаргасан тайлбарыг хүлээн авах үндэслэлгүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт, шаардлагыг биелүүлээгүй, зөрчсөн нь Үндсэн хуулийн Цэцгийн хуралдааны хэлэлцүүлэг, хавтаст материалд авчигдсан нотлох баримтуудаар хөдөлбөргүй батлагдаж байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн Цэцгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцгийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. «Орон нутгийн харьяалаалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай» Монгол Улсын Их Хур-

лын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоолын 4 дүгээр заалтын 3 дахь хэсгийг хэвээр үлдээж, бусад заалтыг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолыг хүчинтэй хэвээр үлдээсэн Улсын Их Хурлын 1992 оны 12 дугаар сарын 22-ны 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

Дарга  
Гишүүд:

Г. СОВД  
Г. НИЯМДОО  
А. БААСАН  
Ц. ЦОЛМОН  
Н. ЖАНЦАН  
Ж. ЧОЙЖАНЦАН  
Ж. БЯМБАА  
Б. ДАНГААСҮРЭН  
Д. ЧИЛХААЖАВ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН  
ХУУЛИЙН ЦЭЦИЙН  
ТОГТООЛ

1993 оны 3 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдааныг Цэцийн дарга Г. Сөвд даргаалж, гишүүн Г. Нямдоо, А. Баасан, Ц. Цолмон, Н. Жанцан, Ж. Чойжанцан, Ж. Бямбаа, Б. Дангаасүрэн, Д. Чилхаажав нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б. Цэндээхүүг оролцуудан хийв. Хуралдаанаар Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд нь

Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 13 дахь заалт, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтуудыг зөрчсөн тухай маргааныг дахин хянан хэлэлцэв.

Хуралдаанд маргагч талуудыг төлөөлж Улсын Их Хурлын нтгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр Улсын Их Хурлын гишүүн Г. Ганболд, Ц. Нямдорж, С. Нямзагд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нтгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Б. Түмэн, шадар туслах П. Цагаан, шинжлэгчээр Монгол Улсын Их Сургуулийн ЭЗСЭШХ санхүүгийн төвхимний эрхлэгч, эдийн засгийн ухааны дэд доктор Д. Дуламсүрэн, Төр нийгэмийн судлаачын академийн төвийн эрхлэгч, эдийн засгийн ухааны дэд доктор Б. Намсрай, Цагдаагийн дээд сургуулийн ахлах багш, хууль зүйн ухааны доктор С. Жанцан, Төр нийгэмийн судлаачын академийн эрдэм шинжилгээний ажилтан Ц. Оюунбаатар нар оролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч 1993 оны 1 дүгээр сарын 11-нд Үндсэн хуулийн цэцэд хандаж Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дэхь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд харилцаж байна гэж үзэж уг асуудлыг авч хэлэлцэж дүгнэлт гаргаж өгөх хүсэлтийг Цэцэд албан ёсоор тавьжээ. Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б. Дангаасүрэн Ерөнхийлөгчийн хүсэлтийг үндэслэн 1993 оны 1 дүгээр сарын 14-нд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэж, холбогдох шалгалт хийжээ. Үндсэн хуулийн цэц 1993 оны 2 дугаар сарын 10, 11, 12-ны өдрүүдэд хуралдаж, Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу үүссэн маргааныг авч хэлэлцэв. Маргааныг хэлэлцэх явцад Ерөнхийлөгчийн нтгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөх Б. Цэрэндорж иргэнийхвэ хувьд хэд хэдэн асуудал хөндөж мэдээлэл өгснийг аман магадлагаар энэ маргаантай хамтран шийдвэрлэхээр тогтсоны дотроос Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчсөн тухай асуудлыг хуралдаанаар хэлэлцэн авч үзвэл цэц дүгнэлтээ оруулан Улсын Их Хуралд өргөн толилуулав. Цэцийн дүгнэлтэд заахдаа:

«1. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дэхь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь «... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгаар», «Улсын Их Хурал ...хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгааж шийдвэр-

авиа» гэж гэсэн Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Хүн амын оролгын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь «Монгол Улсын иргэн хуулиар ижилдүүлсэн албан татвар төлөх», «Улсын Их Хурал ...хуульд оролдолуу оруулах» асуудлыг өөрийн сонгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ» гэсэн Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

3. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэсэн «Татварын байцаагчийн бие хамгаалах тусгай хэрэгслийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно» гэсэн нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж үзэж байна» гэжээ.

Үндсэн хуулийн цэцгийн энэ дүгнэлтийг Улсын Их Хурал 1993 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа авч хэлэлцээд «Үндсэн хуулийн цэцгийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй» гэсэн заалат бүхний 22 тоот тогтоол гаргажээ.

Үндсэн хуулийн цэцгийн хуралдааны хэлэлцүүлэгт Ерөнхийлөгчийн нэгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон П. Цагаан нэлүүдэхдээ: «Бид хүмүүнлэг нийгэм байгуулах, Үндсэн хуулиа дээдэлэн сахих тухай ярьж байгаа. Хуучин бол гүйцэтгэх засаглалд түүгээр ч барэхгүй гэж галд хамаг эрх мэдэл төвлөрч, бүх юмыг байдалж байсан. Одоо бол өөр. Аливаа хууль Үндсэн хуульд бүрэн нийцэж байх ёстой. Үүнийг үндэслэн Татварын Ерөнхий хуулийн 4 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хүн амын оролгын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 1-ийн заалтуудыг үнэхээр зөрчиж сайгаа юм». Үндсэн хуулиар бол хууль тогтоох цорын ганц байгууллага бол Улсын Их Хурал байгаа. Иргэд зөвхөн хуулиар ногдуулсан албан татварыг л төлөх ёстой. Үүнээс үүдээд Засгийн газрын тогтоосон, өөрөөр хэлбэл хуулиар тогдуулаагүй татварыг төлөхгүй байх эрхтэй байж болно. Засгийн газар татварын хувь хэмжээ тогтоосон тохиолдолд шүүгч хуулийг хэрэглэх бич тогтоолыг хэрэглэж болох юм. Нөгөө талаар Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улс бол төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс гэдгийг анхаарах ёстой. Үүнээс үндэслэлд манай улс татварын нэг нэгдсэн бодлоготой байх ёстой гэдгийг сайн бодолцох хэрэгтэй юм. Үүнийг харгалзан үзэхгүй бол цаашдаа Монгол Улсын төрийн хүчийг

суаруулах алсын үр уршиг, аюультай байж болзошгүй гэсэн эмзэглэл бидэнд байгаа. Засгийн газар татварын хувь хэмжээ тогтоох тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхгүй болчих тал гарч бас болно. Одоо би Б. Цэрэндоржийн итгэмжилсний дагуу Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтаар байр сууриа хэлье. Энэ заалтын баталгааны ач холбогдолтойг үгүйсгэхгүй. Гэхдээ хүний эрх чөлөөнд хаалдаж байгаа хэрэг даруй мөн болдог. Иймэвс бие хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх журмыг заахад хуулиар тогтоох ёстой гэж үзэж байна. Тэгэхгүй бол манай улсын нэгдэж орсон иргэний ба уас төрийн эрхийн тухай одон улсын Пактын 9 дүгээр зүйлийн заалттай давхар харшилна» гэв.

Их Хурамын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Нямзагд мэдүүлэхдээ «...Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хуулийн заалтад харшилаж байгаа эсэхийг шийдэх эцсийн шатанд бид ирээд байна. Бид Д. Дэмбэрэлийн нлэрхийлсэн байр суурийг дэмжсэн хэвээр байгаа. Энд нэг зүйлийг бид сайн ойлгох ёстой гэж бодож байна. «Эрх олгосноор», «хууль тогтоомжийн дагуу» гэсэн хоёр зүйлийг ойлгоход эрх шинжүүлээгүй гэдэг нь ойлгогдох ёстой юмаа, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг ингээд шийдвэл практик талаас нь авч үзвэл Улсын Их Хурал аахар шаахар зүйлийг хийж болох юм. Нөгөө талаар төвлөрдөх ихдэж ёстой хуучинсаг байдал тогтомог хуучинсаг гэдэг үгийг би давтан хэлж байна. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг яагаад хаячихаж болсоо. Үүнээс ард түмэн а хохирно. Бид бол ийм хохирол гаргуулахгүй байх зорилготой. Ер нь би асуудлыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 7 дахь хэсгээр шийдэж өгөөч гэж хүсч байгаа юм. Бид хайгуул хиймээр байна. Жишээлбэл, яагаад Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хэрэглэж болдоггүй юм бэ гэх мэт. Үндсэн хуулийг зөрлөөгүй гэсэн байр сууриа дахин нлэрхийлж байна. Цэцгийн түрүүчийн хуралдаан дээр хүрсэн түвшингээс цааш явах саналтай байна» гэв.

Тусгай мэргэжилд шаардсан зарим асуудлауудаар бие даасан шинжээчдийн 2 хэсгийг томилж дүгнэлт гаргуулав.

Шинжээчдийн нэгдүгээр хэсгийг Шинжлэх ухааны академийн ЭЗХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, эдийн засгийн ухааны доктор Г. Пурэнбаатар, Монгол Улсын их сургуулийн ЭЗСЭШХ санхүүгийн тэнхимийн эрхлэгч, эдийн засгийн ухааны дэд доктор Д. Дуламсүрэн, ТНСА-ийн төвийн эрхлэгч,

эдийн засгийн ухааны дэд доктор Б. Намсрай нарын бүрэлдэхүүнтэй байгуулаж дөр дурдсан эдийн засгийн асуултаудыг тавьж харнуул гаргуулав. Үүнд:

1. Үндсэн хуульд звасан «албан татвар» гэсэн ухагдахууныг «хураамж», «төлбөр» гэсэн ухагдахуунтай нэгтгэж адилтгасан нь эдийн засгийн агуулга, арга зүйн хувьд зөв үү?

Харнуул: Албан татвар нь хураамж, төлбөрөөс зарчмын хэд гэдэгн ялгаатай, нэгд, өмчтөний орлогын тодорхой хэсгийг төрийн (нийгмийн) хэрэгцээнд албан журмаар дайчлах утга санааг албан татвар илэрхийлдэг бол хураамж, төлбөр нь үйлчилгээний үнэ хөлсний шинжтэй байна. Хоёрт, албан татвар нь осон нэмэгдэх, шууд хамааралтай, буурах шинжтэй бөгөөд энэ нь албан татварын хувь, хэмжээгээр тодорхойлогддог бол хураамж, төлбөрт ийм шинж байдаггүй. Гуравт, албан татвар ногдуулах хувь хэмжээг тогтоох эрхийг төр эдэлдэг (буюу төр дангаар шийдвэрлэдэг) бол хураамж, төлбөрийн хэмжээ нь үйлчилгээ, ашиг-лаатын хэмжээ, тухайн үеийн зах зээлийн үнэд тулгуурлаж тогтоогддог. Дөрөвт, албан татвар бол эдийн засгийн зохицуулаалтын үндсэн хэрэгсэл юм. Нийт эдийн засагт учирсан хүндрэл бэрхшээл, өнцлөг нөхцөл байдлаас шалтгаалсан албан татварын концессийг боловсруулж, түүнд тулгуурлан албан татварын тогтолцоог бүрдүүлдэг. Харин хураамж, төлбөр, нийт эдийн засгийн зохицуулаалтын хэрэгсэл болдоггүй. Тавд, албан татвар нь хүн амын орлогыг жигдрүүлэх хэрэгсэл болдог бол хураамж, төлбөрт ийм зориулалт байдаггүй. Зургаад, албан татвар ба хураамж төлбөрийн зорилого, үндэсрэл, хэрэгжүүлэх болон хяналт тавих арга хэлбэр, хүлээх харнууллага ч өөр байна. Энэ бүхнээс үзэхэд албан татварыг хураамж, төлбөртэй адилтгах нь эдийн засгийн агуулга, арга зүйн хувьд буруу юм.

2. Эдийн засгийн онолын үүднээс авч үзвэл албан татвар, хураамж, төлбөрийг бий болгох, өөрчлөх, хүчингүй болгох гэдэгт тэдгээрийн хувь хэмжээ багтаж, үндсэн элемент нь болдог уу?

Харнуул—Албан татвар, хураамж, төлбөрийн аль алины хувьд тэдгээрийг төлөгч буюу субъект, татвар оногдуулах зүйл буюу объект, албан татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ нь үндсэн элемент болно. Албан татварыг шинээр бий болгох, өөрчлөх, хүчингүй болгоход түүний хувь хэмжээ нь уг албан татварын шинж чанарыг тодорхойлдог учраас түүний цом болсон асуудал юм.

3. Үнэ өссөн, нөхтөний ханш буурахад хүн амаас хураах татвар өөрчлөгдөж байх ёстой юу?

Хариулт—Үнийн осолт, мөнгөний ханшийн жолоодлоготой бууралтыг харгалзан зүй амын орлогоос хураад албан татварын бодлого өөрчлөгдөж, орлогын зэрэглэл, хувийг өөрчлөх шаардлага гарч болох юм.

4. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «Засгийн газар үнийн осолтийн түвшнийг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнэ» гэсэн заалт эдийн засаг, эрх зүйн хувьд зөв үү?

Хариулт—Албан татвар ногдуулах орлогын хэмжээ, шатлал ба албан татварын хувийг гагцхүү Улсын Их Хурал өөрчлөх эрхтэй. Учир нь гэвэл албан татвар ногдуулах орлого ба хувь нь эдийн засаг, нийгмийг удирдаж, зохицуулах бодлого, механизмийн чанартай тулгуур том асуудал. Ард түмний аж байдалд ч шийдвэрлэх ач холбогдолтой. Энэ бэйр суурингаас авч үзвэл, татвар ногдуулах орлого, хувийг өөрчлөх, зохицуулах эрхийг гүйцэтгэгч байгууллагад (Засгийн газарт) эдлүүлэх нь утгагүй хэрэг. Хэрэв энэ эрхийг Засгийн газарт шилжүүлбэл зардлаа хорогдуулахын оронд албан татварыг нэмэгдүүлж, үйлдвэрлэгчдийг хохироож, ачааллын хүндийг хүн амын нуруунд тохоход хүргэж болзошгүй юм.

Шинжээчдийн хоёрдугаар хэсгийг Цагдаагийн дээд сургуулийн ахлах багш, хууль зүйн ухааны доктор С. Жанцан, ТНСА-ийн эрдэм шинжилгээний ажилтан Ц. Оюунбаатар, Улсын ерөнхий прокурорын туслах О. Баяраа нарын бүрэлдэхүүнтэй байгуулаж хууль зүйн чанартай 3 асуулт тавьж харуу авсан. Үүнд:

1. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бие хамгаалах тусгай хэрэгсэл гэдэгт юу юу багтах вэ?

Хариулт—Цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлэх баталгааны тухай хуулийн гуравдугаар зүйл, энэ зүйлийн хэм хэмжээг хэрэглэх тухай Ерөнхий прокурорын зөвшөөрлөөр Цагдаагийн ерөнхий газрын даргын 1990 оны А/8 тоот тушаал, энэ тушаал, зөвгөрт өөрчлөлт, нэмэлт оруулсан 1991 оны 6/76 дугаар тушаалд бие хамгаалах тусгай хэрэгсэлд дараахь зүйлийг хамааруулжээ.

Үүнд:

- а) гар, дөл, хурууны гав;
- б) хүлэг;
- в) өрсөх цамц (номхтох цамц);
- г) хаймран бороохой;
- д) ВСА—888, ЖА—90,306,6804, ГАК—1, ДИГ—1, 2,



ВК—763 маркийн хүний биед цочрол үүсгэх үйлчилгээтэй цахиагаан боросхойнуул;

е) КО—5001, Оригинал Т—1000 маркийн нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулах, амьсгал боогдуулах үйлчилгээтэй шүршигч;

ё) одон хүнд нөлөөлөх нулимс асгаруулах, амьсгал боогдуулах хийн цэнэгтэй гар буу;

ж) авто тээврийн хэрэгслийг албадан зогсоох төхөөрөмж;

з) усан хөөрөг зэрэг болно. Оросын Холбооны Улс болон бусад орнуудад утаан хөшиг (манан) үүсгэгч бие хамгаалах тусгай хэрэгслийн тсэнд ордог. Эдгээрийг цагдаагийн ажилтан гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлийг засан зогсоох, гэм буруутай этгээдийн халдаага, довтолгооноос өөрийн болон иргэдийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, түүнийг дайчлан баривчлах, цагдаагийн байгууллагад албадан хүргэхийн тулд хэрэглэж байна.

## 2. Тэдгээрийг ямар үед хэрхэн хэрэглэх вэ?

Хариулт—Татварын байцаагч нь түүнийг албан үүрэгтэй нь холбогдуулан эсвэл үүргээ гүйцэтгэж байх үед нь идэвхтэй эсэргүүцлээ үзүүлсэн, амь бие, эрүүл мэндэд нь халдахаар завдсан, бодит халдаага хийсэн нь халдагчийн үйл хөдөлгөөн, үг хэллэгээр батлагдаж байвал сая бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэж болно. Татварын байцаагч нь гүйцэтгэж байгаа үүргийн онцлогоос шалтгаалж зөвхөн өөрийгөө хамгаалах зорилгоор нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч (шүршигч) нулимс асгаруулах, амьсгал боогдуулах хийн цэнэгтэй гар буу хэрэглэж болно.

3. Төрийн төлөөлөгчийн бие хамгаалах тусгай хэрэгслийг жагсаалт, түүнийг хэрэглэх журмыг прокурорын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэх байгууллага тогтоож болох эсэх?

Хариулт—Бие хамгаалах тусгай хэрэгслийн төрөл, түүнийг хэрэглэх журмыг гүйцэтгэх байгууллага тогтоож Улсын ерөнхий прокурор зөвшөөрөл өгөх тэдгээр хянаж ирсэн нь «Бүх яам, албан газар, одон нийтийн болон хоршооллын байгууллага, албан тушаалтан, иргэдээс хуулийг хэрхэн бислүүлж байгаад дээд хяналтыг Улсын прокурор гүйцэтгэнэ» гэсэн хуучин Үндсэн хуулийн 72 дугаар зүйлийн заалт, түүнчлэн 1976 онд батлагдсан Прокурорын хяналтын хуулийн 15 дугаар зүйлийн «а» хэсэгт заасан хэм хэмжээг хэрэгжүүлж ирсэнтэй холбоотой.

Улсын прокурорын зөвшөөрснөөр НАХЯ-ны сайд (одоогийн Цагдаагийн ерөнхий газрын дарга) бие хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх журмыг батааж ирсэн нь Цагдан сэр-

гнйлэх байгууллагын 1985 онд батлагдсан дүрмийн 19 дүгээр зүйлийн «номхотгох тусгай хэрэгслийн жагсаалт, тэдгээрийг хэрэглэх журмыг НАХЯ-ны сайд, Улсын прокурорын зөвшөөрснөөр батална» гэсэн заалтаас урган гарч байна.

1990 онд батлагдсан «цагаан сэргийлэх, эвсэн хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлдэг баталгааны тухай» хуулийн дөрөвдүгээр зүйлд дээрх журмыг дахин хуульчлан баталгаажуулжээ.

Дээр дурдсан хуулийн заалт нь бие хамгаалах тусгай хэрэгслийг Монгол Улсын Ерөнхий прокурорын зөвшөөрснөөр гүйцэтгэх төв байгууллагын дарга батлах замаар хүний эрхийг хязгаарлахад чиглэгдсэн эрхийн акт гаргах нөхцөл бүрдүүлж, хууль тогтоогчийн эрх эдлэхэд хүргэж байсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн «хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч илгэнх, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно» гэсэн хүний эрхийн халдашгүй байлалыг хангах тухай хэм хэмжээтэй нэг зөрчилдөж байна гэж үзэж байна.

Төрийн төлөөлөгч албан үүргээ биелүүлж байгаа үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх нь хүний эрх, эрх чөлөөг бодитой хязгаарлах, амь бие, эрүүл мэндэд нь хохирол учруулахад хүргэдэг тул Монгол Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхийнхээ дагуу галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг эрх бүхий төрийн төлөөлөгчийн гүйцэтгэж байгаа албан үүргийн онцлог, хэрэгжүүлэх арга, эрх хэмжээг харгалзан тус бүрд нь цагаартайгаар тогтоож, энэ тухай бие даасан хууль гаргах нь зүйтэй гэж үзэж байна гэжээ.

#### Хянавал:

Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: «Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнө» гэж заасан нь үнэ өссөн тохиолдолд иргэдийг татварын дарамтаас чөлөөлөх гэсэн агуулга бүхий чухал заалт боловч Улсын Их Хурлаас хуульчлан тогтоосон хэм хэмжээг өөрчлөх шууд утгыг илэрхийлж байгаа, ийнхүү өөрчилснөөр ногдуулах татварын хувь хэмжээ өөрчлөгдөхгүй байх баталгаагүй, нөгөө талаар албан татвар ногдуулах орлогын хэмжээг өөрчлөх, зохицуулах эрхийг хуулийн биелэлтийг зохион байгуулах үүрэг хүлээсэн Засгийн газарт илалжүүлсэн зэрэг нь Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б. Цэрэндорж Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 2 дугаар сарын

10-ны өдрийн хуралдаан дээр иргэнийхээ хувьд Татварын ерөнхий хуулийн хэд хэдэн заалт Үндсэн хуульд харшиаж байна гэж албан ёсоор мэдэвчлэн хийж цац авч үзэхийг хүссэний дотор мөн хуулийн 28 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн «...бие хамгаалах тусгай хэрэгсэлийн жагсаалт, түүнийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын хөшөөрсөөр Улсын татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно» гэсэн нь Үндсэн хуулийн заалтад харшиаж байгаа тухай асуудлыг Цэц бүрэлдэхүүнээрээ ам цагадлаа гарган хүлээн авч дүгнэлт гаргасан, түүнчлэн энэхүү хуралдаанд Б. Цэрэндорж хүндэтгэх шаалтгаалаар биеэр оролцож члдаагүй учир өөрийгөө Цэцэд төлөөлөх эрхийг Б. Түвшин, П. Цагаан нарт албан ёсоор (бичгээр) олгосныг буруу гэж үзэх үндэслэлгүй байна.

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дээрх заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт «Иргэн ...халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, ...хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно» гэж заасныг шууд зөрчиж байгаа бөгөөд бие хамгаалах тусгай хэрэгсэлийн жагсаалт, түүнийг хэрэглэх журмыг хуулиар тогтоох ёстой байтал гүйцэтгэх байгууллагууд тогтоож байхаар заасан нь буруу болжээ.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх нь цаэгийн хуралдааны хэлэлцүүлэг, бусад нотлох баримтаар хангалттай нотлогдохгүй байгаа тул энэхүү хоёр заалттай холбогдох маргааны талаар нэмэлт шалгалт хийх шаардлагатай гэж цаэгийн гишүүдийн дийлэнх олонхи нь санал өгсөн тул энэ асуудлыг улс төр, хууль зүй, эдийн засгийн мэргэжил бүхий хамтарсан шинжилгээ томилж дүгнэлт гаргуулах замбар дахин нэмэлт шалгалт хийсэний үндэст Цэц эцэслэн шийдвэрлэхээр хойшлуулах нь зүйтэй гэж үзэв.

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь «Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх», «Улсын Их Хурал ...хуульд өөрчлөлт оруулах... асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ» гэсэн Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн нь Цэцгийн хуралдааны хэлэлцүүлэг, хялгаст материалд авгагдсан нотлох баримтуудаар хөдөлбөргүй батлагдаж байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 66 ду-

гаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «Бие хамгаалах тусгай хэрэгслэлийн жагсаалт, түүнийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно», Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг сорчлан» гэсэн заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хууль зорчсон тусгай маргааныг Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг үндэслэн нэмэлт шаалгалт хийсний эцэст Цэц дахин хянан хэлэлцэж эцэслэн шийдвэрлэхээр хойшууласугай.

3. Энэ тогтсоод эцсийн шийдвэр тул гармагцдаа хүчин төгөлдөр болно.

Дарга  
Гишүүд:

Г. СОВД  
Г. НЯМДОО  
Х. БААСАН  
Ц. ЦОЛМОН  
Н. ЖАНЦАН  
Ж. ЧОЙЖАНЦАН  
Ж. БЯМБАА  
Б. ДАНГААСҮРЭН  
Д. ЧИАХААЖАВ

## «ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ» СЭТГҮҮЛИЙН НИЙТЛЭЛИЙН ХАВСРААЛТ

№ 2

*Ушигчиддаа сонордуулах нь:*

«Төрийн мэдээлэл» сэтгүүлийн нийтлэлийн хавсралтад Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн цэцийн ажил үйлсээс тогтмол мэдвэлнэ.

Улсын Их Хурлаас батлан гаргаж байгаа хууль тогтоомжийг хэрхэн яаж хэрэгжүүлэх тухай мэргэжлийн хуульч, эдийн засагчдын бичсэн эдийн засаг, хууль зүйн тайлбарыг хэвлэнэ.

Улсын Их Хурлын хавар, намрын чуулганы зарим хуралдааны тэмдэглэвэлээс сонирхуулна.

Ушигчдын асуултад хариулна.

### ГАРЧИГ

1. Ж. Норовсамбуу. Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо нийм асуудлыг эрхэлнэ.
2. Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүдийн намтар
3. Ч. Базуу. Азийн зарим орны парламент
4. Ч. Базуу. Хаягаа тодорхой бичээрэй.
5. Б. Болд. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эхлэл, харилцаа

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО ИЙМ АСУУДЛУУДЫГ ЭРХЭЛДЭГ

Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан шийдвэрлүүлж байна. Манай байнгын хорооны өдөр тутмын анхааралд хүн амын хүнсний хангамжийн талаар төрөөс явуулах бодлогыг хуульчлан тодорхойлох, үндэсний баялаг болсон мал сүргийг төрийн хамгаалаалтад байгаа бодлогыг тодорхойлож биелэлтэд нь хяналт тавих, мал аж ахуй, газар тариалан, хүнсний, малын уамын сан эрүүд мөндрийг хамгаалах төрийн бодлогын үндсийг тодорхойлож мал эмнэлэг үржлийн болон хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалтын байдалд хяналт тавьж ажлаах явдал байнгын анхааралд байна.

Мал эмнэлэг, үржлийн албаны тогтолцоог тодорхойлох, газар тариалан эрхлэх төрийн бодлогын үндэслэлийг тогтоох, хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэл, бодлогын үндсийг тодорхойлох нь тус байнгын хорооны үндсэн үүрэг мөн.

Хүнс, хөдөө аж ахуйн асуудлаар шинээр байгуулах болон цуцлах олон улсын гэрээ хэлэлцээрийн үндсийг тодорхойлно. Төрчлэн хүнс, хөдөө аж ахуйн олон улсын байгууллага, бусад орны парламентын холбогдох хороо, комисстой харилцаа холбоо тогтоох, хөгжүүлэх асуудлыг эрхлэн гүйцэтгэдэг.

Хамгийн чухал нь Улсын Их Хурлаас хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн асуудлаар гаргасан хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж ажлаах нь байнгын хорооны эн тэргүүний зорилт юм.

Байнгын хорооны дарга Ж. НОРОВСАМЕУУ

## НАДМИДЫН БАЯРТСАЙХАН

Н. Баяртсайхан 1962 онд Улаанбаатар хотод төрсөн. 1978 онд Увс аймагт Улаангом хотын дунд сургуулийг төгсөөд Холбоот Орос Улсын Эрхүү хотын Улс ардын аж ахуйн дээд сургуульд элсэж 1982 онд хөдөлмөрийн эдийн засагчийн мэргэжлээр төгсчээ. Сургууль төгсөөд Д. Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуульд ассистент багш, багшаар ажиллаж байв.

1989—1992 онд Москва хотод Оросын Удирдлагын Академийн аспирантурт суралцаж, үйлдвэрлэлийн үр ашгийг урамшуулах асуудаар эдийн засгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна.

1992 оны 6 дугаар сард явагдсан Улсын Их Хурлын сонгуулиар Увс аймаг дахь 15 дугаар тойргоос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ.

Эхнэртэй, 2 охинтой.

## ДОЛООНЖИНГИЙН ИДЭВХТЭН

Д. Идэвхтэн 1953 онд төрсөн. 1961—1971 онд ерөнхий боловсролын дунд сургууль, 1971—1977 онд ЗХУ-ын (хуучин нэртэй) Краснодар хотын Политехникийн дээд сургуульд суралцаж төгсчээ. Инженер-механикчийн мэргэжилтэй.

1977—1980 онд Улаанбаатар хотын худалдааны техникумд багш, хичээлийн эрхлэгч, 1980—1983 онд Худалдааны төхөөрөмжийн засвар, зардал мэдээллийн газарт ерөнхий инженер, орлогч дарга, 1983—1985 онд Худалдаа, бээтгэлийн яамны Хөрөнгө оруулалт, материал хангамжийн хэлтсийн дарга, 1985—1990 онд МАХН-ын гөн хороонд уас төрийн ажлтан, 1990—1992 онд Өмнөговь аймгийн МАХН-ын хороонд даргаар тус тус ажиллаж байв.

1992 оны 6 дугаар сараас Монгол Улсын Их Хуралд гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Гэр бүлтэй, хүүхэдтэй.



## ЖАМЪЯНГИЙН ЖАДАМБАА

1947 онд Архангай аймгийн Ихтамир сумын нутагт төрсөн. Нийгмийн гараа малчин, яс үндэс халх. МАХН-ын гишүүн.

Ж. Жадамбаа 1955—1965 онд бага, дунд сургууль, 1970 онд Монгол улсын их сургуулийн барилга инженерийн анги төгсчээ. 1984 онд намын дээд сургууль төгссөн, 1970 онд Дархан хотын барилга угсралтын конторт инженер, 1973—1976 онд хотын ХЭЭ-ийн хороонд ажилчин залуучуудын хэлтсийн эрхлэгч, 1976—1982 онд хотын намын хороонд зохион байгуулагч, хэлтсийн эрхлэгч, 1984—1987 онд Дундговь аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга, 1987—1990 онд Намын Төв Хороонд зохион байгуулагч, хэлтсийн зөвлөх, 1990—1992 онд Дархан хотын МАХН-ын хорооны даргаар ажиллаж байгаад 1992 оны 6 дугаар сарыг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ам бүл 3. Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

## ЖАМБЫН НОРОВСАМБУУ

1942 онд Ховд аймгийн Дарви сумын нутагт малчин ардын гэр бүлд төржээ.

Ж. Норовсамбуу 1950—1960 онд бага, дунд сургууль, 1960—1965 онд Хөдөө аж ахуйн дээд сургууль төгсч, маалын их эмч мэргэжилтэй болсон бөгөөд 1978—1980 онд Москвад намын дээд сургууль төгссөн байна.

Ж. Норовсамбуу МАХН-д 1964 онд элссэн. Тэр 1965—1970 онд Дорнод аймгийн Баянтүмэн суманд маалын их эмч, 1970—1975 онд Дорнод аймгийн мал эмнэлэгийн газрын халдвартын их эмч, газрын дарга, 1975—1978 онд Дорнод аймгийн Баян-Уул сум, Онон сангийн аж ахуйн дарга, 1980—1982 онд Сангийн аж ахуйн яамны орлогч сайд, 1982—1984 онд Сэлэнгэ аймгийн Сант сум, Цагаантолгойн сангийн аж ахуйн дарга, 1984—1986 онд Ховд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, 1986—1992 оны 2 дугаар сар хүртэл Сэлэнгэ аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байв. 1992 оны 2 дугаар сараас Улсын Бага Хурлын гишүүнээр, 1992 оны 7 дугаар сараас Улсын Их Хурлын гишүүнээр тус тус сонгогджээ. Одоо Улсын Их Хурлын Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар ажиллаж байна.

Ардын Их Хурлын 10, 11, 12 дахь удаагийн сонгуулиар Ардын Их Хурлын депутатаар сонгогдож байсан байна.

Ж. Норовсамбуугийн ажлын үр бүтээлийг төр засгаас үнэлж Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон, Ардын хувьсгалын 50, 60, 70 жилийн ойн медалиудаар шагнажээ.

Ам бүл 6. Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

## ДОГДОМ ОВОГТОЙ ДАГВАСҮРЭН

1947 онд Дорнод аймгийн Дашбалбар суманд төрсөн. Нийгмийн гараа малчин, Яс үндэс бурнад, МАХН-ын гишүүн.

1963 онд Дорнод аймгийн Бани-Уул сумын 10 жилийн дунд сургууль, 1967 онд Одесса хотын Хүнс ба Хөргөлтний технологийн дээд сургууль, 1982 онд Москва хотноо Нийгмийн ухааны академ төгссөн байна. Хүнсний үйлдвэрийн инженер механикч мэргэжлэтэй, улс төрийн дээд боловсролтой, 1992 онд БНСУ-ын Сеул хотноо Засгийн газрын дэргэдэх удирдах ажилтны мэргэжлд дэвшлүүлэх институтад суралцаж зах зээлийн асуудлаар мэргэжлд дэвшлүүлжээ.

1968 оноос Дорнод аймгийн Махкомбинатын барилга захиалагчийн төлөөлөгчийн газарт техник хяналтын инженер, 1969 оноос Махкомбинатын ерөнхий инженер, 1973—1980 онд мөн комбинатын даргаар ажиллаж байв. 1982 оноос Дорноговь аймгийн намын хороонд үйлдвэр, худалдаа, тээврийн асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга, 1983—1987 онд Дорноговь аймгийн АДХТЗ-ны дарга, 1987—1989 онд ТТМТХЕ Газар, комплекс-импорт хангамжийн нэгдээд намын үүрийн нарийн бичгийн дарга 1990—1991 онд Улаанбаатар хотын намын хороонд улс төрийн ажлтан, намын ажлын төвийн захирлаар ажилласан, 1991—1992 онд Дорнод аймгийн Ардын Хурлын Тэргүүлэгчид, Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны даргаар ажиллаж байгаад 1992 оны 6 дугаар сард Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ.

Ардын Их Хурлын 9, 11 дэх удаагийн сонгуулиар Ардын Их Хурлын депутатаар сонгогдож байсан байна. Ардын хувьсгалын 50, 60, 70 жилийн ойн медалнар шагнуулжээ. Үндэсний сурин харваачаар Улсын мэргэн, спортын мастер цол зэргээр шагнагдсан байна.

Ам бүл 7, эхнэр, 5 хүүхдийн хамт амьдардаг.

## ЖАМБАЛДОРЖИЙН УРТНАСАН

Ж. Уртнасан 1942 онд Ховд аймгийн төв-Жаргалант хотод сэтгэлтний гэр бүлд төржээ. Ард хлаах, МАХН, МҮЭ ийн гишүүн 1950—1960 онд бага, дунд сургууль, 1960—1965 онд Хөдөө аж ахуйн дээд сургуульд суралцаж төгссөн. Мэргэжлээр нь мөч ширгэжигнатой. 1965—1967 онд Шинжлэх ухааны академийн биологийн ухааны, 1967—1975 онд мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрвэлэнд эрдэм шинжилгээний ажилтанар, 1975—1987 онд мөн хүрвэлэнд эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан бөгөөд 1978 онд «Бэлчээрийн малдлагааны нөхцөлд монгол хонины бие махбодид хужир, шүүний нөлөө, тэжээлийн ач холбогдол» сэдвээр мал эмнэлгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна.

1987—1990 онд Хүнс, хөдөө аж ахуйн яаманд мал аж ахуй эрхэлсэн орлогч сайд, 1990 оноос Сайд нарын Зөвлөлд ахлах референтээр ажиллаж байв.

Ардын Их Хурлыг сонгох 12 дахь удавгийн сонгуулиар Ардын Их Хурлын депутатаар, Улсын Бага Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байсан бөгөөд Нэгдлийн Холбооны Дэд Зөвлөлийн (хуучин нэрээр) даргаар 1991—1992 онд ажиллав. 1992 онд Ардын Их Хурлын даргаар сонгогдож Монгол Улсын Үндсэн хуулийг батлуулах ажилд идэвхтэй оролцож их хувь нэмэр оруулсан билээ.

Гэр бүлтэй, эхнэр, ээжийн хамт амьдардаг. Хүүхдүүд нь нас бие гүйцэж эрх тусгаарласан байна. Нэг эвэстэй.

## МИНЖҮҮРИЙН ДАЛАЙХҮҮ

1950 онд Архангай аймгийн Өгнийнуур суманд төрсөн, найгмийн гараг малчин, яс үндэс халх, МАХН-ын гишүүн.

1961—1971 онд Архангай аймгийн төвийн 10 жилийн сургууль, 1971—1976 онд Монгол улсын их сургууль, 1983—1985 онд НДС-ийг тус тус төгссөн. Авто тээврийн төлөвлөгч зохион байгуулагч мэргэжилтэй.

1976—1983 онуудад Булган аймгийн төлөвлөгөөний комисст мэргэжилтэн, 1985—1987 онд Архангай аймгийн намын хооронд заварлагч, 1987—1990 онд Архангай аймгийн Хашаат сум-нэгдлийн дарга, 1990—1992 онд Архангай аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны I орлогч, аймгийн даргын алба хашиж байсан. 1992 оны 6 дугаар сараас Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ.

Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг.

## ЦЭРЭНПИЛИЙН НАМХАГНЯМБУУ

Завхан аймгийн Сонгино суманд 1947 онд төрсөн, хэлх. 1961—1992 он хүртэл төрж өссөн сумандаа хонь харилсан Монгол улсад нэрд гарсан мэргэжлийн хоньчин хүн.

1978 онд түүнд БНМАУ-ын хөдөлмөрийн баатар цолыг хүртээжээ. Сүхбаатарын болон Хөдөлмөрийн гавьяаны улаан туг, Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Ардын хувьсгалын 50, 60, 70 жилийн ойн медалиар шагнуулсан байна.

1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон

Ам бүл арван нэгүүлээ. 9 хүүхэдтэй.

## АЗИЙН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТ

Филиппиний ийнсада Мансла хотод болсон Азийн 12 орны парламентад туслах албадми ажилтны бүсийн зөвлөлдөх уулзалтад ороцож, тэдгээр орны төлөөлөгчидтэй санаа бодосо солилцон Филиппин, Шри-Ланка, Тайвань хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаатай танилцах бололцоог АНУ-ын Азийн сан бидэнд олгосон юм. Чинхээр сонссоноос нүдээр үзэж харсан нь илүү итгэлтэй байдаг болохоор ажилтай нь танилцсан зарим орны парламент, түүний тамгын газрын тухай уншигчиддээ товч ч болов танилцуулахыг үүргээ гэж үзлээ.

*Филиппинд:* Филиппиний хууль тогтоох байгууллага нь хоёр тахимтай юм. Бид тэр хоёрын тахимын хуралаанд орж ажиллаж танилцаж Конгрессийн дарга нь зөвлөлдөх уулзалтад оролцогчдыг хүлээн авч уулзав. Пакистан, Монголдос очсон хүмүүс Филиппины конгрессийн судалгаа сургалтын албаны удирдлага, конгрессийн нарийн бичгийн дарга нарын газрын ажилтан, эрдэмтэдтэй ярицаллаа, хичээл хийж Филиппины Сенат, Конгресс, тэдгээрийн Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, боловсон хүчний үйл ажиллагаатай танилцан.

Филиппины Конгресс 230 гишүүнтэй, үүний 200 нь сонгогддог, бусад нь томилогдсон байна. 43 байнгын хороотой юм. Хуулийг 3 удаагийн уншилтаар баталдаг байна. Нарийн бичгийн дарга нарын газар нь Ерөнхий нарийн бичгийн дарга, түүний 2 орлогчийн удирдлагаар ажилладаг. Захиргааны болон үйл ажиллагааны (судалгаа, шинжилгээний) хэлтэстэй. Тэр дотроо хэсгүүдэд хуваагддаг. Захиргааны хэлтэс нь захиргааны ажлын хэсэг, боловсон хүчний хэсэг, үйлчилгээний хэсэг, санхүүгийн хэсэг, аж ахуйн хэсэг, эрүүл мэндийн хэсэг, хэвлэл олшруулах хэсэг, нягтлан бодохын товчоо, материал хангамжийн товчоо, инженерийн хэсэгтэй юм.

Үйл ажиллагааны хэлтэс (судалгаа шинжилгээний хэлтэс) нь дотроо судалгаа, лавламжийн товчоо, хуулийн хэсэг, хууль тогтоомжийн төсөл зохиох, зөвлөлдөх өгөх хэсэг, хороодын ажил эрхэлсэн товчоо, хурлын ажил эрхэлсэн товчоотой юм. Номын сан нь архивын хэсэгтэй. Ажиллагаа нь бүрэн компьютержжээ. Номын сангад улс төр, өдийн засгийн бүх төрлийн мэдээлэл, лавламж гаргадаг. Парламентын гишүүдийн захиалгаар мэдээлэл гаргаж өгдөг байна.

Конгрессийн гишүүн бүр 6 ажилтантай, Тамгын газарт 500 гаруй бүтээлч ажилтан ажилладаг, Тамгын газрын ажилчдад тогтвортой ажилладаг, Конгрессын гишүүдийн туслах нь тэднийг өөрчлөгдөхөд хамт өөрчлөгддөг. Нарийн бичгийн дарга нарын газар нь аж ахуй, санхүүгийн хувьд бүрэн биеэ дааж, хамгаалагчын алба бүтэц, бүрэлдэхүүнд нь орж ажилладаг байна.

Үйл ажиллагааны буюу судалгаа, шинжилгээ-авчархгийн хэлтэс, түүний хэсгүүд нь орж ирсэн хуулийн төслийг болон гаргаж байгаа хуулийг бүртгэх, ангилж, хуулийг бэлтгэж гаргах график, хувийн хэрэг хотоодог. Ямар нэг хууль гаргах санаагаас эхлээд хууль болж гаргах хүртэлх бүх ашмыг энэ хэлтэс хариуцан гүйцэтгэдэг байна. Хуульд хөдөөмөрдийн санаа авч тусгах, хорсоод хууль бэлтгэж байгаа явцад хяналт тавих ажлыг мөн хийдэг ажээ. Энэ хэлтэс, түүний хэсгүүдэд бүгд 62 хүн ажилладаг. Хуулийн төслийг буюу санаамыг агаад үндсэн хуультай хэрхэн нийцэж байгаа, өөр хуульд уг асуудалыг галсан эсэх, уг хууль гаргах буюу санаамыг тусгаснаар бусад хууль төгтоомжид өөрчлөлт орох эсэх, олон улсын хуультай хэр нийцэх зэргийг судлан боловсруулдаг байна. Олон янзын төсөл, санаа байвал тэднийг хооронд нь харьцуулан судалж санаа боловсруулдаг.

Хуулийн төслийг нэр зээсэн хороонд хугаарилж өгдөг. Хороо нь дэд хороондоо шилжүүлдэг. Дэд хороо нь хуулийн төслийг боловсруулж хэлэлцээд тайлан бичиж хорсондоо иргүүлж өргөн барьдаг. Байнгын хороо боловсруулж дуусаад дүрмийн хороонд хүлээлгэж өгдөг. Дүрмийн хороо нь чуулганд оруулах талаар зохицуулж шийдвэрлүүлдэг ажээ. Сенатын болон конгрессын 2 хорооны санаа зөрөөтэй байвал уул 2 хороог уулзуулж зохицуулдаг. Судалгааны хэсэг нь статистик мэдээ, бусад мэдээлэл, хэвлэлд нийтэлсэн зүйлийн цуглуулга, хуулийн төсөлд холбогдох бусад бүх материал бэлтгэдэг. Парламентын үйл ажиллагааг олон түмэнд мэдэгдэх ажлыг үйл ажиллагааны хэлтэс зохицуулж хийдэг. Боловсон хүчнийг ажилд авах ажиллуулах журмытай, өөр газар ажиллаж байгаа юм уу сургуульд сурч байгаа хүмүүсээс сонгож авдаг. Сурч байгаа хүнийг судалж, ажил дээрээ дадлагашуулах, степендийн хэсгийг төлөх зэргээр сургууль төгсөхөс нь өмнө сонгож авдаг байна. Ажилд авах хүнийг боловсон хүчин тэр хүнийг ажиллуулах хэлтэстэй нь хамтран судлаад ерэнхэн нарийн бичгийн дарга шийдвэрлэдэг ажээ.

Финландын сенат, конгрессод тамгын газраас гадна Засгийн газрын бус байгууллаага-судалгаа сургалтын алба ажилладаг байна. Энэ нь Их Сургуулийн нэг факультетэд байгаад түүгээрээ



сдаж бие дааман алба болоод 2 ина болжээ, 16 ажигтантай. Хоёр талхины ажигтнуудын уулзалт төрөлжсөн семинар яриуцлага хийж ажигтныг ажлад сургах, харилцан туршлага солилцох, бусад байгууллаагчид Сенат, Конгресс, тэдгээрийн Тамгын газартай ойр холбоотой ажиллаахад тусладаг. Мөн парламент, түүний Тамгын газарт шаардлагатай мэдээлэл олж цуглуулан төрөлдөг. Хуулиудад судалгаа хийж өгдөг. Хуулийн төслийн талаар яриуцлага зохион байгуулдаг байна.

Парламентын гишүүдийг сонгогчиддоо хэт автхаас хамгаалж үндэсний шийтдэг эрх ашиг баримтлахад хүний туслахуудад нь зөвлөдөгөө өгч тусалжээ. Сенатын гишүүд юу хийж байгааг судалж, конгрессын үйл ажиллагааг сурталчлан мэдээлэх ажил зохиожээ. Энэ зорилгоор улирал тутам мэдээллийн сэтгүүл гаргадаг байна. Энэ алба нь ямар нэг намын үзэл баримтлалдгүй, аль ч намын нөлөөнд ордоггүй байна.

*Шри-Ланка:* Тус улсын парламент 225 гишүүнтэй, үүний 125 нь эрх баригч намын, 100 нь сөрөг хүчний төлөөлөгчид гэнэ. Парламентын сонгууль 6 ина тутамд болдог. Сар бүрийн 1, 3 дель 7 хоногт хуулийн хуралдагддаг, 2, 4 дэх 7 хоногт парламент хуралдаддаггүй. Тус улс 26 яамтай бөгөөд тэдгээрийн сайдууд нь парламентын гишүүн байдаг байна.

Парламент нь 1979—1982 онд Японы Мицуури гэдэг компаниар баригдсан тохиолот сайхан ордонтой. Парламентын чуулганыг ихэвчлэн ирээдүй ашигдэг, харин зөвлөлдөх хороо, байнгын хорооны хуралдаан нь ихэвчлэн хяалттай болдог юм байна. 225 гишүүнээс 20 гишүүн ирсэн байхад хуралдааныг хүчинтэй гэж үзэж асуудал шийддэг ажээ. Зөвлөлдөх хороо нь ихэвчлэн салбарын асуудлыг өөрийн эрхэлсэн чиглэлийн дагуу хянаж шалгадаг. Нэг зөвлөлдөх хороо дунджаар 22 гишүүнтэй, бүрэлдэхүүнд нь Парламентын жирийн гишүүнээс гадна Засгийн газрын сайдууд, сөрөг намын гишүүд ааваал ордог. Харин байнгын хороо нь ихэвчлэн хууль боловсруулан батлуулах ажлаа хариуцдаг.

Парламентын чуулганы талхиддаа гишүүд нь эрх баригч намын, сөрөг намын гэж 2 хуваагдаад урд урддасаа харж суудаг, саналаа Сөсч өгдөг юм байна. Хурлын дарга нь талхимаа голлон ганцгараа суудаг бөгөөд түүний урд Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2 орлогчтойгоо суудаг байна.

Тамгын газар нь тусна, үйлчилгээний ажилчдыг оруулаад 1000 орчим ажиллагсдтай бөгөөд шинэчлэл аппарат нь 600 орчим хүнтэй, Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга толгойлох бөгөөд тэр нь дорно 2 орлогчтой. Ерөнхий нарийн бичгийн

дэргыг Ерөнхийлөгч хугацаагүй томилдог. Ерөнхий нарийн бичгийн дарга нь хурлын даргатай зөвлөж Тамгын газрын бусад бүх ажилтнаа томилдог гэнэ.

Танхимд бичиг зөвдөг ажилтнаас эхлээд Ерөнхий нарийн бичгийн даргаа хүртэл олон зэрэг тогтоож, энэ зэрэгтээ тохирсон цалин өгдөг юм байна. Тамгын газрын ажилтнуудын цалин нь хувийн салбарын ажилтнуудынхаас доогуур, улсын бусад байгууллагын ажилтнуудынхаас арай дээгүүр юм байна. Тамгын газар ажилд хүн авахдаа бичгийн ба аман яриуцлага хэлбэрээр шалгалт авдаг. Тодорхой шалгуурууд байдаг байна. Жишээ нь тухайн албан тушаалаас хамгаарч дээд мэргэжилтэй байх, явцад улсын байгууллагад яаад эвх нь 10 жил ажилласан байх гэх мэт. 1—2 жил доод шатны ажилд ажиллауулж байгаад дадалга эзэмшсэний дараа зохих ажилд нь томилдог. Тамгын газрын ажилтнууд нам бус байх ёстой гэнэ.

Тамгын газрын ажилтнуудын талаар тусгай хуультай. Энэ хуулиар ажилтнууд ямар давуу эрх эдлэхийг зааж өгдөг. Жишээ нь: 35 км-ээс цааш гэртэй хүмүүст автобусаар үнэгүй зорчих биелэл олгох, ажил тарах, ирэхэд төв замын дагуу автобусаар хүргэж өгч авдаг. Зарим ажилтан формын хувцастай, үдийн хоол хөнгөлөлттэй үнээр өгдөг. 50 насандаа тэтгэвэрт гарах (энэ нь бусад салбарын ажилтнуудаас арай эрт гарч байна гэсэн үг юм) жилд 3 удаа галт тэргээр үнэгүй явах, арай хямд үнээр эмнэлэгт хэвтэх, чуулганы үед цалингийн тодорхой хувийг нэмэгдэл болгож авах, парламентын гишүүд амраагүй үед төдийг үйлчилдэг амралтад амрах гэх мэт.

Бидний уулзаж яриуцсан зарим хэлтсийн ажлаас товч дурдвал:

Хурлын тэмдэглэл харнууцсан хэлтэс.—Өдөр тутмын хуралдааны мэдээг хэвлэлийн газарт өдөр нь өгч, маргааш өглөө нь хэвлэн бэлэн болгодог. Протоколыг 3 хэл дээр (сингал, тамга, англи) хөтөлдөг. 50 протокол хөтөлгөч ажилладаг. Хуралдааны материалыг доросоо дэвшээ шат дараалан хянаж, хөнгийн сүүлд орлогч редактор, редактор хянаад хэвлээд илгээжүүлдэг юм байна. Чуулганы чөлөө цагт эдийн протокол хөтөлгөчид дорсооны хурамын протокол бас хөтөлдөг. Бичлэгт хэн ч гарын үсэг зурдаггүй бөгөөд харин албан ёсны товч дүгнэлтэд Ерөнхий нарийн бичгийн дарга гарын үсэг зурдаг. Бичлэгийг гишүүдэд өгч үнэн зөнийг нь хянуулаад ном болгож номын сандаа 1 хувийг өгдөг. Тэнд 15 жил хадгалаад дараа нь Засгийн газрын архивт хадгалдаг байна.

Аюулгүй байдлын хэлтэс.—Энэ нь ёслол, үйлчилгээ, байр

сууц хамгаалаат, цэвэрлэгээ, тэвээр, холбоо харлуудаг. Шри-Ланка улсад парламентын ордонг хүчтэй хамгаалдаг. Парламентын ордон руу зөвхөн ганц замаар ордог бөгөөд орж байгаа хүнийг олон давхар шалгана. Харин ордон сайн хамгаалаалттай тул чуулганы тэнхимдээ хамгаалаалтын хүн тавьдаггүй. Хамгаалаалтын албаныхан ордонд болж байгаа гол үйл явдлуудыг төлөвлөөр харж хянадаг юм байна.

Шри-Ланкийн парламентад гишүүд хуралдаан орхиж явдаг тохиолдол байдаг бөгөөд хуралдаандаа ирээгүй гишүүнийг цуглуулахад аппаратын ажилтнууд оролцдоггүй. 3 сэр хуралдаанд ирээгүй гишүүн бол гишүүн бус болдог хуультай юм байна.

Нийтлэг зүйл. — Финанши, Шри-Ланкийн парламентын Тамгын газар ажилтнуудаа дотор нь байнгын, гэрвэгээр түр ажилладаг гэж ангиаж байна. Эдгээр улсад улсын байгууллаагад ажиллагсдыг авч ажиллуулах, тэдний цалин хөлс хангамжийн тухай дүрэмтэй бөгөөд, тэр дүрмийг нарийн бичгийн дарга нарын газар мөрдөхийн зэрэгцээ өөрийн эрх хэмжээ, онцлогийн дагуу нэмэлт зарим журам гаргаж, түүнээ мөрдөж ажилладаг байна. Парламентын гишүүд өөрсдөө туслах ажилтантай байж болдог бөгөөд түүний зардыг улсаас гаргаж өгдөг. Тэр ажилтан гэрвэгээр ажиллаж байгаад гишүүнийг өөрчлөгдөхөд хамт чөлөөлөгддөг юм байна.

Парламентын гишүүдэд туслах хүмүүс нь хууль тогтоох болон сонгогчидтойгоо ажиллах, сонгогчдын санаа бодлыг судлахад аль алинд нь тусалдаг. Тэгэхдээ улсын нийтлэг эрх ашигт нийцүүлэхэд анхаардаг байна. Эдгээр орны парламент нь Тамгын газраас гадна олон нийтийн болон эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, эрдэмтдийн тусламцааг авч ажилладаг. Тэгэхдээ тэд нь ямар нэг намын үзэл бодол, зорилгыг агуулдаггүй байна.

Парламент дахь намын бүлгүүдэд орон тооны цөөн хүн ажилладаг. Тэдэнд нарийн бичгийн дарга нарын газар өрөө тасалгааны тусламцаа үзүүлдэг аж. Эдгээр улсын алинд ч гэсэн өрөө тасалгаа хүрэлцээгүй, нэг өрөөнд олуулаа ажилладаг байна.

Азийн орнуудын хууль тогтоох байгууллаагад туслах албадын зөвлөхөд уулзалтад оролцогчдын хэлсэн үг, тэдэнтэй уулзаж ярилцсан болон дээрх орны парламентын Тамгын газрын ажилтай танилцсанаас дүгнэж үзэхэд манай Улсын Их Хурал, түүний Тамгын газрын зохнон байгуулаалтын бүтэц, үйл ажиллагаа нь зөв зохистой зохион байгуулагдан явагдаж байна гэж үздэштэй байна.

## ХАЯГАА ТОДОРХОЙ БИЧЭЭРЭЙ

1992 оны эхний 2 сард Улсын Бага Хурал, түүний Тамгын газарт 112 захидал ирж байсан бол Улсын Их Хурал, түүний Тамгын газар 1993 оны эхний 2 сард 424 санаал хүсвэл, гомдол мэдээллийг агуулсан 328 захидал хүлээн авч 307-г нь хянан шийдвэрлэж зохих хүмүүст харну өгөөд байна.

Эдгээр захидалын дотор нэг хуудсанд бичээд нэг буюу 10, 20 хүн гарын үсэг зурсан, түүнчлэн янз бүрийн баримт бичиг, хурлын тэмдэглэл хавсаргасан хэдэн арван хуудас зүйл ч байдаг. Хичнээн хүн, хэдэн хуудсанд бичсэн ч байлаа гэсэн тэдгээрийн гол агуулга, санаа нь улс орондоо хүнлэг энэрсэнгүй ардчилсан нийгэм байгуулах, эвх зээлд шилжих үйл ажлаагааг зөв чиглүүлж явуулах, амьдралд хэрэгжих бүрэн үндэслэлтэй, олон түмний нийтлэг эрх ашигт нийцсэн боловсролгүй хууль гаргах, өндөр настан, олон хүүхэдтэй эхчүүд, ядуу дорой хүмүүсийн амьдралын баталгааг хангах, зохион байгуулалт, сахнага дэг журмыг сайжруулахтай холбогдсон санаа, хүсвэл голыг нь эзэлдэг.

Улсын Их Хурал, түүний Тамгын газарт энэ оны эхний хоёр сард орон нутгийн иргэдээс ирүүлсэн захидалын тоо урьд саруудаас нэлээд нэмэгдэж нийт захидалын 40 шахам хувийг эзэлж байна.

Албан татварын багуу хууль, Тэтгэврийн хууль, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Ерөнхийлөгчийн сонгуулийн зуулийг хэвлэцэж батлах үеэр иргэдээс ирүүлсэн санхалыг Улсын Их Хурал анхааралтай судалж харгалзан үзлээ. Улсын Их Хурлын гишүүд хураалдаанд бүрэн оролцдоггүй, зарим асуудалд нэг талыг барьж туйлашран хэт маргах, сонгогчидтойгоо бололцоо гарган уулзахгүй байна гэж шүүмжилсэн болон хүнсний бараа, зарим үйлчилгээний үнэ, тариф хэт өсч амьдралын баталгаа алдагдааа гэж бухимдсан захидал, сонордуулах бичиг ч цөөнгүй ирлээ. Энэ бүхнийг Улсын Их Хурлын удирдлага, байнгын хороо, гишүүд анхааралдаа авч судлан холбогдох арга хэмжээ авахуулж байна.

Телефоны болон орон сууцны цахилгаан өргүүр, хөг хангалын хураамжийг нэмсэнтэй холбогдон олон иргэд захидал бичиж гомдол гаргасныг Улсын Их Хурал онцгой анхаарч Их Хурлын

гншүүд, Тамгын газрын ажигтан, зарим нам, газрын мэргэжилтний оролцоотойгсөр итгисавалын дүүргүүд, холбогдох байгууллагад үзэвг, судлаагаа хийж тодорхой чиглэл, зөвлөмж өгсөний дагуу Засгийн газар эхний арга хэмжээ авлаа.

Үндэснийхээ бичгийг сурч эзэмших нь зүйтэй ч улс орны эдийн засгийн хямралтэй хүнд үед төрийн албан хэргийг хуучин монгол бичгээр хөтлөхөд шууд нэмж их бэрхшээлтэй, амьдраад нийцтэй, дэвшилттэй талаасаа шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэхэд саад учруулж бичиг үсэггүй олон хүн бий болдо гэдгийг анхаарч албан хэргийг хуучин бичгээр хөтлөхийг түлгээсэн хэс бичигтэн болох бодлого явуулж зохих арга хэмжээ авахыг хүсч эрдэнтэн, судлаач, багш, зохиолч, ажигтан олон хүн Улсын Их Хуралд захидал ирүүлснийг Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хороо судлаж байна.

Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны иргэн, хөдөө аж ахуйн ахмад ажигтан Д. Цэнээнжав Маалын удмын санг хамгаалах хууль гаргах гэж байгаатай холбогдуулан ирүүлсэн захидаадаа манай улс дээд, дунд боловсролтой 8000 гаруй мал зүйч бэлтгэсэн. Гэтэл мал зүйчид ажлаагүй, маалын удмын санг хамгааж хөгжүүлэх ажла эзэнгүй болж өндөр ашиг шимт мал үрэгдэж, цаашид мал өсгөхөд их муу үр дагавартай болдоо. Мал сүрэг төрийн хамгаалаалтад байна гэсэн Үндсэн хуулийн зөвлөлийг биедүүлж Маалын удмын сан, эрүүд мэндийг хамгаалах хууль гаргах түүнд мал зүйчид амьдралын тогтоолдоо, аж ахуйн байгууллага, иргэдийн үүргийг тодорхой зааж өгөхийг хүсэлт болгожээ. Хуулийн нэрвэс эхлэн дөрхөн эхихдээ дурьдсан зарим үндсэн санааг уг хуульд тусгасан байна.

Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны иргэн, хөдөлмөр, нийгэм хангамжийн байгууллагын ахмад ажигтан, өндөр настан Л. Пүрэвдорж хөдөлмөрийн сайнага газар сайгүй суларсан нь ажлаа унаж өдлөхгүй байгаагийн нэг үндэс болж байна. Иймд аппаратын дотсод журмыг нарийн тогтоож ажлын цагийг үр бүтээлтэй дүүрэн ашиглах, гадаадаас ажлаах хүч алдгийг зогсоож ажлаагүй залуучуудыг ажлалуулах, жижиг, дунд үйлдвэр байгуулж ажлын байр бий болгон, түүхий эд материалаар хангах арга хэмжээ авах, нийслэлийн дүүргийн тус хэт олширч төв, орон нутгийн Тамгын газар нүсэр орон тоотой аппарат буй болсныг нягтлан үзэж аппаратыг хямдруулах санаа ирүүлснийг зөхөж байнгын хороо хянаж үзэж байна.

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын эрх, үүргийн бичиг орон сууц олгож өгөх, одон медалиар шагнуулах, гэмт хэрэг үйлдээд шийтгэгдсэн хүнд уучлаа үзүүлэх яамыг хөнгөрүү-

лэх тухай өргөдөл бичиж түүнийг нь зарим сум, хороо, албан бичгээр уламжлах явдал ч байгаа нь тэр хүнд тус болохгүй, бие биендээ шилжүүлж бичиг явуулж илүү зардал чирэгдэл болж байгааг анхаарах нь зүйтэй байна. Мөн тэддүгээр хороо, тийм сумын иргэн гэх мэтээр захидал ирүүлсэн хүнд хаяг нь тодорхой бусаас болж хариу өгөхөд бэрхшээл учрах, хариу нь зохих хүндээ хүрэхгүй удах, олон газар дамжиж яваад эргээд ирэх явдал ч байна. Хэн, хаана ч захидал бичлээ ч гэсэн нэр хаягаа гаргацтай тодорхой бичиж байх нь чухал юм.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
захидагч хэсгийн ахлагч Ч. Баянуу

«Төрийн мэдээлэл» сэтгүүлийн зөвлөлд

Сэтгүүлийн зөвлөлийн хамт олонд чин сэтгэлийн мөндчлэгээ дэвшүүдэг! Нийтлэл, уран бүтээл, ажла үйлсдээ өндөр амжилт басхийг хүсье!

Тус сэтгүүлийг захиалаагч уншигч би сэтгүүлийн 1993 оны шинэ анхны дугаарыг дүгээн авлаа. Цаашид захиалаах болно. Уг сэтгүүлийг тогтмол уншсанаар Төр, засгийн бодлого, шийдвэр, Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль, тогтоол, Ерөнхийлөгчийн зарлигууд болон Улсын Их Хурлын эрхэм гишүүн (төрийн түшээ) нарын буурь суурьтай ярицлага, эдийн засагчид, хуульчид, улс төрчдийн бичсэн өгүүлэл, тайлабар, асуудал дэвшүүлсэн өгүүлэл зэрэг олон талын мэдээлэл авч амьдрах, ажилд маань тус болж байдаг юм. Зөвхөн ганц энэ сэтгүүлээс л 1992 оны 12 сараас 1993 оны 1 сарын хугацаанд батаардсан хууль, тогтоол, Ерөнхийлөгчийн зарлигууд болон ямар тогтоол, зарлиг хүчингүй болсон тухай олон зүйлийг мэдэж ойлгон хууль эрх зүйн мэдээг, боловсролоо нэмэгдүүлсний хамт өргөн олон дунд ч хуудна зөв ойлгон алхам тутамдаа хэрэгжүүлж биелүүлэхэд алтай нөлөө үзүүлж байна. Сэтгүүлд нийтлэл, тэмдэглэл, ярицлага, иргэдийн санал, эрэлт хүсэлтийг ч ээлжидэн тоймлон нийтлэсэн нь уншигчдад талаардаж байна.

Мөн Улсын Их Хурлын үйл ажиллагаанаас, мөн уншигчдын хүсэлтээр Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хорооны үндсэн гишүүдийн намтраас нийтэлсэн нь ч сонирхолтой байна.

«Захидал задаахад» буцаанг ч хойшид нээх гэж байгаа нь уншигч одонтой улам ч нягт холбоотой байх үүд хаалгыг нээх нь дамжиггүй.

Сэтгүүлийн нийтлэлийн бодлогод санал нэмэрлэе. Үүнд:

«Төрийн мэдээлэл» сэтгүүлийн уншигчдын хурлыг тогтмол захиалагч, дэвлэлийн төлөөлөгч, сурвалжлагч идэвхтэн бичигчдийн дунд хийдэгж уншигчдаас санал, бодлыг сонсч захиалгыг улам бүр нэмэгдүүлэх:

2. Аймаг бүрт өөрийн гэсэн идэвхтэн бичигч-сурвалжлагчидтай байвал ямар вэ? (орон тооны бус сайн дурын, уг ажилд сонирхолтой);

3. Сэтгүүлд яамдын сайд нарын ярицлага, улс орноо эдийн засгийн бэрхшээлээс хурдан хугацаанд яаж гаргах талаар бодол эргэцүүллийг нийтлэж болох юм.

4. Сэтгүүлд Монгол улсын төрийн зохион байгуулааг, гүйцэтгэх үүргийн талаар схемчлэн нийтэлж бэйваа имэр вэ?

Эцэст тэмдэглэхэд «Далайн зурган ирлэцлэга» товхимлыг эмхтгэн гаргаж уншигч, захиалагчиддаа бэлэг болгон барихвар төлөвлөн ажлалаж байгаад талархаж байна.

Багш Ц. Бор (Дорнод аймаг, Чойбалсан хот, 3-р сургууль)



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАХИДАА ХАРИЛЦАА

Ерөнхийлөгч хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх, тодорхой асуудлаар зарланг гаргах, үүрэг даалгавар, чиглэл, удирдамж өгөхдөө олон түмний санал, бодол эрээт хүсвэлэнд ямагт тулгуурлахыг чармайж ирлээ.

Ерөнхийлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаанд 4500 гаруй үүнээс эвхэн 1993 он гараад 300 шахам захидал түүний нэр дээр болон Тамгын газрын нэвэр дээр ирсэн юм.

Иргэд, төр, аж ахуй, олон нийтийн байгууллагад ажилладаг хэн боловч төр, засгийн дээд байгууллагад аливаа эгзэгтэй, ээдрээтэй, зайлшгүй чухал шаардлагатай гэж үзсэн асуудлаа санал, өргөдөл, гомдлын хэлбэрээр бичиж ирүүлдэг билээ. Эдгээр захидалыг судалж анхааралдаа авахын зэрэгцээ Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд шууд хамаарагдахгүй, харин эрх бүхий байгууллагаар шийдвэрлэвэл зохих асуудлыг ялан холбогдох яам, албан газарт шилжүүлж, арга хэмжээ авахуулах буюу бодлого шийдвэрт нь тусгуулж байна. Иргэдээс ирүүлж байгаа захидалд улс орныхоо өнөөгийн байдал, ирээдүйн төлөө санал зөвж эдийн засгийн хамралыг аль болох түргэн гэтлэн давах, ардчлалыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх, сахлага харилцаага, дэг журмыг сайжруулах, хууль хяналтын байгууллагын ажлыг боловсронгуй болгох зэрэг болон бусад олон асуудлыг хөндөж, авах арга хэмжээний хэлбэрийн талаар санал, бодлоо сэтгэл харамгүй нэрэлж байдагт Монгол улсын Ерөнхийлөгч гүн талархаж байдаг юм.

Оны эхнээс бичсэн захидаудыг судалж үзэхэд улс орны нийгэм-эдийн засгийн байдалд бодитой дүгнээт өгсөн, тодорхой салбарын ажла үйлчилгээтэй холбогдсон санал 40 гаруй ирсний дээр өргөн хэрэгцээний бараа, зарим төрлийн үйлчилгээний үнэ, тариф хэт өсч, мөнгөний ханш эрс буурч, нийгмийн нэвээд хэсэг, түүний дотор өндөр настан, тахир дутуу иргэд, өвчтэй хүмүүс, сичин хүүхэд, бага орлоготой хийгвэд олон хүүхэдтэй айл өрх, төсвийн байгууллагад ажиллагсдын амьдралын байдал эрс муудаж, амьдралын баталгаа алдагдаж байгаад бухимдсан хүмүүс ч цөөнгүй байна.

Эдгээр захидалыг тоогсоор нэрхийлбэл: 8 хувь нь төр, засгийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааны тухай, 7 хувь нь худалдаа, үйлчилгээ, тээвэр, холбоо, боловсрол, соёл, урлагийн салбарын тухай, 6,5 хувь нь орон сууц хүссэн, 4,4 хувь нь зээл, тэтгэвэр, тэтгэмж, тусламж хүс-

сэн, 10 хувь нь шагнал урамшил хүссэн, 20 шахам хувь нь уучлаа хүссэн утгатай байлаа.

Ерөнхийлөгчийн тамгын газрын иргэдийн хүлээн авах байраар энэ он гарсаар 240 шахам хүн ирж дээрх асуудлаар санал бодол, эрвэл хүсэлтээ тавив.

Ирсэн олон захидалд улс орныхоо эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх шилжилтийн үеийн хүндрэлийг гэтлэн давах арга замын талаар өөрийн бодол саналыг илэрхийлэхийн зэрэгцээгээр амьдраад тохиолдож байгаа бэрхшээл зовлонгослолын далайгүй танилцуулсан байна. Бас ажил үйлчилгээ, өргөн хэрэгцээний бараа таваарын үнийн өсөлтөөс хамаарч бага орлоготой өрхийн амьдралын түвшин дордох болсон тухай нэлээд олон хүн баримт жишээ дурдан бичжээ. Мөн үйлдвэрлэлт үйлчилгээний тоо хэмжээ, чанарыг сайжруулахыг олон хүн захидалдаа шаардсан байна.

Төр, засгаас анхаарвал зохих дээр дурдсан асуудлын дагуу зарим тодорхой арга хэмжээ авахуулж байна.

«Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай» хуулийн дагуу бүх шатны засаг дарга нарын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэгдэх олон асуудлаар иргэд Ерөнхийлөгчид хөндөн захидал илгээж байгаа нь тухайн орон нутгийн байгууллагын ажлалтуудаас иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шуурхай барагдуулах талаар цаашид анхаарах шаардлагатай гэдгийг харуулж буй хэрэг юм.

Ерөнхийлөгчийн захидал харилцааны туслах Б. Болд

---

**Сүтгүүлийн зөвлөл:**

Ерөнхий эрхлэгч **Н. Ринчиндорж**  
Нэрийн бичгийн дарга **Сэн. Жаргалсайхан**  
**Т. Балсансүрэн**  
**Ц. Бабуу**

Техник редактор **С. Эгнээлмаа**  
**Хянагч С. Итгэл**

**Зал № 4**

Үйлдвэрт шилжүүлсэн 1993 оны 4-р сарын 21-нд,  
Өрнөлтөд 1993 оны 4-р сарын 22-нд, Хявалатда  
1993 оны 7-р сарын 5-нд, Цаасны хэмжээ  
60х84/16, Хяваллийн хуудас 7,75, Хявалсан тоо  
4000 ширхэг.

**Засгийн газрын хэвлэл үйлдвэр**